

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

НОМЫН САН

ШИНЭ НОМЫН МЭДЭЭ

2021 №02



Эмхэтгэсэн: Номзүйч С.Найгалмаа

М.Золбоо

Улаанбаатар хот

2021 он

ГАРЧИГ

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН.....	1
ФИЗИК-МАТЕМАТИКИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	1
ГЕОЛОГИ, ГАЗАРЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН.....	1-2
БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	3-5
ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	5-6
ХӨДӨӨ АЖ АХУЙН ШИНЖЛЭХ УХААН.....	6
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААН.....	7
НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	7
ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	7-12
ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	12-16
УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	16-18
ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН.....	18-24
ШИНЖЛЭХ УХААН СУДЛАЛ.	24-28
БОЛОВСРОЛ, СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААН.....	28-29
БИЕИЙН ТАМИР.СПОРТ.....	29
СЭТГҮҮЛ ЗҮЙ.....	30-31
МУЗЕЙ. АРХИВЫН АЖИЛ.....	31
ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	31-33
АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ.....	33
УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ.....	33-34
УРАН ЗОХИОЛ.....	35-37
УРЛАГ. УРЛАГ СУДЛАЛ.....	37-39
ГҮН УХААН.....	39
СЭТГЭЛ СУДЛАЛ.....	40
НОМЗҮЙН ЛАВЛАГААНЫ ГАРЫН АВЛАГА.....	40
ГАДААД ХЭЛ ДЭЭРХ НОМ, ЗОХИОЛ.....	41-54

Товчилсон үгийн тайлбар:

БУУТ- Байгалийн ухааны уншлагын танхим /306 тоот/

НХУУТ- Нийгэм, хүмүүнлэгийн ухааны уншлагын танхим- I,II /211, 108 тоот/

ГНОФ- Гэрээр ном олгох фонд-I,II,III /110,201,401 тоот/

ГФ- Гадаад номын фонд /411 тоот/

ЛавФ- Лавлагааны фонд /409 тоот/

ЭШФ- Эрдэм шинжилгээний фонд /411 тоот/

БС- Бизнесийн сургуулийн номын сан /Хич-V 505 тоот/

ХЗС- Хууль зүйн сургуулийн номын сан /Хич-III 205 тоот/

ОУХНУС- Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын

сургуулийн номын сан /Хич-V 304 тоот/

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН

Ой ба хүчилтөрөгч 2020: Улсын хэмжээний эрдэм шинжилгээний онол-практикийн бага хурлын бүтээл.- УБ.: Би Си Ай, 2020.- 62х.- ISBN: 978-9919-20-282-8

Энэхүү бүтээлд 10 гаруй эрдэмтэн багш, судлаачдын "Ой ба хүчилтөрөгч-2020" Улсын хэмжээний эрдэм шинжилгээний онол-практикийн бага хурал дээр тавигдсан эрдэм шинжилгээний илтгэлүүд багтжээ.



20.1

О 23

/БУУТ-7/

ЭШФ Т-24308-24310

ФИЗИК-МАТЕМАТИКИЙН ШИНЖЛЭХ УХААН

Батсүх Г. Физик II цахилгаан соронзон үзэгдэл / Хян. Ц.Баатарчулуун, Б.Жаргал; Эх бэлт. М.Билгүүн.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2020.- 204х.- ISBN: 978-9919-20-619-2

Энэхүү гарын авлагад цахилгаан статик орон, цахилгаан гүйдлийн хуулиуд, цахилгаан соронзон үзэгдэл, цахилгаан соронзон долгион зэргийн талаарх ойлголтыг тусгажээ.

22.33я7

Б 34

ГНОФ 55 15986-15995



Ерөнхий физикийн практикум: Молекул физик / Ред. Г.Шилагарди.- УБ.: МУИС хэвлэх үйлдвэр, 2021.- 191х.- ISBN: 978-9919-504-41-0

Энэхүү ерөнхий физикийн практикумын гарын авлага нь молекул физикийн лабораторийн 20 ажлыг багтаасан бөгөөд физик судалж буй мэргэжлийн болон мэргэжлийн бус хөтөлбөрийн оюутнуудад зориулагджээ.

22.36

Е 701

/БУУТ-10, ГНОФ-17/

ЭШФ Т-24485-24487



ГЕОЛОГИ. ГАЗАРЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН

Авирмэд Э. Монголын агуй / Ред. Д.Доржнамжаа, Э.Батсайхан.- УБ.: Намнан хэвлэл, 2020.- 332х.- ISBN: 978-9919-23-603-8

Энэ ном нь үндсэн 7 бүлэг 35 дэд бүлгээс бүрдэнэ. Олон улсын агуйн судалгааны өнөөгийн түвшин болон монгол оронд хийсэн агуйн судалгааны тойм, мөн агуйн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах асуудлыг хөндөхийн зэрэгцээ агуйн аялал жуулчлал, агуйн спортыг хөгжүүлэхэд агуйн судалгаа чухал ач холбогдолтой болохыг харуулжээ.




26.823(1)

А 178

/БУУТ-6/

ЭШФ Т-24119-24121



Газарзүйн асуудлууд сэтгүүл=Journal of geographic issues: №20 / Ред. Д.Амартүвшин; Техник ред. Д.Ганпүрэв; Редакцийн зөвлөлийн гишүүд В.Батцэнгэл, П.Мягмарцэрэн, Д.Даш, М.Баянтөр.- УБ.: МУИС пресс, 2020.- 109х.

Уг бүтээлд газарзүйн таксон буюу нутаг дэвсгэрийн нэгжийн хил тогтооход газарзүйн элементүүдийн үүргийг онцлон тодорхойлсон судалгаа Монгол орны хэмжээнд одоогоор хомс байгаа тул үүнийг судалгааны асуудал болгон хөндсөн. Монгол улсын 21 аймгийн нутаг дэвсгэрийн газарзүйн хилийн жишээн дээр уг судалгааг гүйцэтгэв.


Энэхүү судалгаагаар нийт 21 аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд ялгарч буй газарзүйн нутаг дэвсгэрийн нэгжийн /дотоод/ хилийг тодорхойлж буй газарзүйн зонхилох элементүүдийг судлан тогтоожээ.

26.8я43

Г 161

/БУУТ-2, ЛавФ-1/

ЭШФ Т-24330-24331



Монгол орны ландшафтын экологийн чадавх=Landscape ecological potential of mongolia / Ерөн. ред. Э.Авирмэд; Эх бэлт. О.Мөнхдулам; Хавтасны зур. Б.Баянжаргал.- УБ.: Намнан Дизайн, 2020.- 402х.- ISBN: 978-9919-23-153-8

Энэ нэгэн сэдэвт бүтээл нь 11 бүлэг, 157 зураг, 125 хүснэгт, бүхий 402 хуудастай. Өөрийн болон гадаад орнуудад хийгдсэн судалгааны сурвалж материалуудад үндэслэн судалгааны арга зүй сонгож, олон эх сурвалжийн мэдээг ашиглан шалгуур үзүүлэлт тус бүрээр 8 сэдэвчилсэн давхарга үүсгэж, зураг давхцуулалтын орчин үеийн

технологи (машин сургалтын арга газарзүйн мэдээллийн системд суурилсан орон зайн олон шалгуурт шийдвэр гаргалтын арга, шаталсан дүн шинжилгээний арга)-ийг ашиглан сэдэвчилсэн давхаргуудыг нэгтгэж зургийг 1:1000000-ын масштабтай боловсруулсан болно.

26.82(1)

М 692

/БУУТ-6/

ЭШФ Т-24116-24118



Уур амьсгалын өөрчлөлт, хандлага-2020: Улсын хэмжээний эрдэм шинжилгээний онол-практикийн бага хурлын бүтээл / Эмхт. Ч.Заяа; Ред. Б.Батдэлгэр, Б.Цэнгэл.- УБ.: Би Си Ай, 2020.- 122х.- (Монгол-Кувейтын Байгаль Хамгаалах Төв).-ISBN: 978-9919-20-281-1

Ногоон хөгжлийн үзэл санаанд тулгуурласан, экологийн өөрчлөлт түүний тэнцвэр алдагдаж байгаад урьдчилан сэргийлэх, хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Монгол-Кувейтын Байгаль Хамгаалах Төвөөс эрдэмтэн судлаач, оюутан залуучуудын дунд зохион байгуулсан онол-практикийн бага хурлын илтгэлүүдийг

тус эмхтгэлд оруулжээ.

26.237

У 594

/БУУТ-7/

ЭШФ Т-24305-24307

БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Богд хааны ордон музейн шувууд / Хян Д.Өсөхжаргал, Ж.Мөнх-Эрдэнэ, Ч.Ууганбаяр; Гэрэл зургийг Д.Жешке, С.Гомбобаатар, О.Соронзонболд; Хэвлэлийн эх, загвар П.Даваасүрэн, С.Гомбобаатар.- УБ.: Монголика хэвлэлийн газар, 2019.- 113х.- ISBN: 978-99978-67-42-1



VIII Богд Жавзандамба хутагт тэртээ 1901 онд Германы Хамбург хотод амьтдын чихмэл хийлгэж байжээ. БСШУСЯ, МУИС -ийн биологийн тэнхим, Монголын шувуу судлалын нийгэмлэг, ХБНГУ-аас Монгол улсад суугаа элчин сайдын яам Германы Зенкенбергийн байгалийн түүхийн музей, манай музейн хамт олны зүтгэлээр 2016-2017 онд шувуудын чихмэлийг сэргээн засварлаж, зүйлийн нэр тайлбар, тархац зэрэг шинжлэх ухааны нарийвчилсан судалгааг эрдэмтэн С.Гомбобаатар нар гүйцэтгэснийг энэхүү бүтээлээс сонирхоно уу.


28.6с

Б 525

/БУУТ-2/

ЭШФ Т-24110-24111

Гомбобаатар С. **Монгол орны биологийн олон янз байдал**: Тэргүүн боть: Нугаламгүй болон нугаламт амьтдын зүйлийн жагсаалт=Biodiversity of Mongolia: A checklist of invertebrate and vertebrate animals / Эмхт. С.Ганзориг, Ч.Аюушсүрэн, Ж.Батцэцэг ба бус; Хян. С.Гомбобаатар, С.Шар, У.Айбек ба бус.- УБ.: Монголика хэвлэлийн газар, 2019.- 317х.- ISBN: 978-9919-9518-1-8



Тус ном нь Монгол оронд одоогоор бүртгэгдсэн нугаламт амьтдын 760 зүйл (78 зүйлийн загас, 6 зүйл хоёр нутагтан, 23 зүйлийн мөлхөгч, 513 зүйлийн шувуу, 140 зүйлийн хөхтөн амьтад), 5,919 зүйл нугаламгүй амьтдын зүйлийн жагсаалтыг багтаасан төдийгүй, бүхий л зүйлийн нугаламт амьтдын монгол нэрийг шинээр болон өөрчлөн оноосон монгол, англи хэлээр хамтран хэвлүүлсэн манай орны хувьд анхдагч бүтээлүүдийн нэг ажээ.


28.688(1)

Г 531

/БУУТ-5/

ЭШФ Т-24104-24106

Монгол орны биологийн олон янз байдал=Biodiversity of Mongolia: Ургамал, мөөг, бичил биетний зүйлийн жагсаалт=A checklist of plants, fungi and microorganisms: Дэд боть= Vol.2 / Эмхт. М.Ургамал, Б.Оюунцэцэг, Э.Энхжаргал ба бус.; Хян. С.Гомбобаатар, Д.Суран, Н.Сонинхишиг.- УБ.: Монголика хэвлэлийн газар, 2019.- 410х.- ISBN: 978-9919-9518-2-5




Уг бүтээлд Монгол улсад бүртгэлтэй гуурст ургамлын 3,163 зүйл, хөвдийн 570 зүйл, замгийн 2,248 зүйл, мөөгний 630 зүйл, хагийн 1,069 зүйл, бичил биетний 241 төрлийн зүйлийн жагсаалт багтсан ба мөн гуурст ургамлын бүхий л зүйлд монгол нэрийг шинээр болон өөрчлөн оноосон юм. Энэ бүтээл бол ургамал, мөөг, бичил биетний төрөл, зүйлийн нэгдсэн жагсаалтыг монгол, англи хэлээр хамтран хэвлүүлсэн манай орны хувьд анхдагч номуудын нэг болно.

28.588(1)

Г 531

/БУУТ-4/

ЭШФ Т-24107-24109



Монгол орны малын бэлчээрийн гуурст ургамал= Rangeland plants of Mongolia: I боть: Өндөр уулын бүслүүр, уулын ойт хээрийн бүслүүр, хээрийн бүс=High mountain belt, Mountain forest steppe belt, Steppe zone / Ред. Ж.Ундармаа, Н.Яманака; Диз. П.Содбаатар, З.Нямцэрэн.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 650х.- ISBN: 978-99978-740-7-8


Энэхүү бүтээлд өндөр уул ба уулын ойт хээрийн бүслүүр, хээрийн бүсийн ургамлын төлөөлөл болох 297 зүйл ургамал болон бэлчээрт тохиолдох зарим ховор, унаган, чимэглэлийн болон тарьж хэрэглэвээс зохилтой ургамал, зарим хортой ургамлыг багтаажээ. Мөн ургамлын бүтэц, ургах орчныг харуулсан гэрэл зургийг шинэчилсний дээр бүх ургамлын тархацын мэдээг Монголын гуурст ургамлын конспект бүтээлд зааснаар баяжуулав.

28.58(1)

М 692

/БУУТ-2/

ЭШФ Т-24112-24113



Монгол орны малын бэлчээрийн гуурст ургамал=Rangeland plants of Mongolia: II боть: Цөлийн хээрийн бүс, цөлийн бүс, бүс бусын бэлчээр=Desert steppe zone, Desert zone, Extra zone / Ред. Ж.Ундармаа, Н.Яманака; Диз. П.Содбаатар, З.Нямцэрэн.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 498х.- ISBN: 978-99978-740-8-5

Энэхүү бүтээлд цөлийн хээр, цөлийн бүс, нуга, намаг, нам хотос, давслаг хөрстэй бэлчээрийн болон хөл газрын ургамлын төлөөлөл болох 215 зүйл ургамал болон бэлчээрт тохиолдох зарим ховор, унаган, чимэглэлийн болон тарьж хэрэглэвээс зохилтой ургамал, зарим хортой ургамлыг багтаажээ. Мөн ургамлын бүтэц, ургах орчныг харуулсан гэрэл зургийг шинэчилсний дээр бүх ургамлын тархацын мэдээг Монголын гуурст ургамлын конспект бүтээлд зааснаар баяжуулсан байна.

28.58(1)

М 692

/БУУТ-2/

ЭШФ Т-24114-24115



Эм, цэцэрлэгийн ургамал: Соёмбо нэвтэрхий толь / Ерөн. ред. Ч.Содномцэрэн, Ц.Цэндээхүү, Х.Жамъяндорж; Техник ред. Б.Эрдэнэбулган, С.Батчимэг, Ж.Очир; Хавтасны дизайн эх бэлт. Б.Эрдэнэбулган, Б.Ариунбаяр, Г.Батмөнх ба бус.- УБ.: Соёмбо пресс, 2020.- 488х.- ISBN: 978-99978-63-81

Энэхүү нэвтэрхий толь нь Ботаник, ургамлын аж ахуй, генийн нөөц, интродукцийн шинжлэх ухааны мэдлэгийн үндэс-сорилт, туршилт, судалгаа, шийдэл, инноваци, бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, технологийн тогтолцооны уулзвар зааг болсон Агрономын шинжлэх ухааны ээдрээт зарим хэсгийг ч болов өргөн том утгаар нь эзэмших, ашиглахад хялбар, сонирхолтой, түүхчилсэн хэлбэрээр баяжуулж баталгаажуулан ойлгож ашиглахад

хамгийн өргөн, түгээмэл танин мэдэхүйн ойлголт өгч мэдээллийг мэдлэг, мэдлэгийг баялаг болгон ашиглахад чиглэгдсэн анхдагч эх материал болно.

28.5я2

Э 52

/ГНОФ-2, БУУТ-6, ЛавФ-1/

ЭШФ Т-23935-23937

ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААН

Гантоого Ё. **Үйлдвэрийн цахилгаан хангамж:** Тооцооны аргачлал, жишээ, лавлах материал / Ред. А.Ариунболд.- УБ.: Шинэ өнгө, 2020.- 256х.- ISBN: 978-9919-20-795-3

Энэхүү бүтээлд үйлдвэрийн цахилгаан хангамжийн өгөгдөл, тооцоо болон тооцоо бодох аргачлалын талаар тусгасны дээр тооцоонд шаардлагатай өгөгдөл, лавлагаа материалыг хавсаргажээ.

31.19я73

Г 21

/БУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-24488-24490



Гантөмөр Ш. **Цахилгаан шугам сүлжээ, систем:** Их дээд сургуулийн сурах бичиг, жишээ бодлого / Хян. Ж.Шагдарсүрэн.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 1000х.- ISBN: 978-99978-830-0-1


Энэхүү сурах бичигт цахилгаан шугам сүлжээ, системийн үндсэн тоноглол, тэдгээрийн хийц, бүтэц, ажиллах зарчим, ажлын горим, холбогдох тооцоо зэргийг оруулжээ.

31.2я73

Г 233

/БУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б-30388-30390



Мэдээллийн технологийн паспорт шалгалтад бэлтгэх гарын авлага / Санаачлагч П.Наранцэцэг; Зөвлөх Э.Цогтгэрэл, Н.Чулуунбанди, А.Энхбат; Ерөн. ред. Н.Мөнхбаяр, С.Уянга; Ред. Н.Мөнхбаяр, Ч.Мөнхнасан, Э.Батцэцэг ба бус.; Техник ред. Б.Сонинцэцэг; Эх бэлт. О.Батсүрэн, Ж.Баянбаатар, М.Шинэжаргал.- УБ., 2021.- 368х.- ISBN: 978-9919-24-200-8

МТИШ нь Япон болон Азийн орнуудад мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэхээс гадна тухайн улсын шинжлэх ухаан, технологи, боловсрол, санхүү, эрүүл мэнд дэд бүтэц зам тээвэр зэрэг бүх салбар болон салбар дундын ажил үйлчилгээг Нэг хэл-Нэг стандартаар гүйцэтгэх зорилготой юм. Энэхүү гарын авлага нь тус салбарт хамаарах хууль эрх зүйн актууд, стандарт, ёс зүйн дүрэм ба мэдээллийн технологийн мэргэжлийн онолын мэдлэгийг дээшлүүлэх, шалгалтанд бэлтгэхэд тус болохуйц чухал мэдээлэлийг багтаасан байна.

32.973-018.я7

М 949

/ГНОФ-5, БУУТ-7/

ЭШФ Т-24482-24484





Харькина О.В. **Бохир усны биологи цэвэрлэгээний байгууламжийн үр дүнтэй ашиглалт, тооцоо** / Хян. Мойжес Станислав Игоревич, Щеголькова Наталия Михайловна; Хөрв. Ц.Чимэдхорол, Г.Буд; Хөрвүүлгийг хян. М.Л.Песчаная.- Волгоград: Панорам, 2015.- 416х.- ISBN: 978-5-9666-0172-0

Энэхүү номонд бохир усны биологи цэвэрлэгээний байгууламжийн зураг төслийг азот, фосфорыг арилгах технологитойгоор боловсруулах, тооцох ашиглалтын ажиллагааг явуулах, бохир ус цэвэрлэгээний байгууламжуудад явагддаг биологи үзэгдлийн мөн чанар болзошгүй эвдрэл, гэмтэл болон бусад хүний хүчин зүйлээс үүдэлтэй саатал, доголдол бүрт үйл ажиллагааны зохистой арга хэмжээг хэрэгжүүлэх боломжоор хангагдсан зураг төслийн оновчтой шийдлийг гаргах талаар тусгажээ.

38.761.2

X 23

/БУУТ-7/

ЭШФ Б-30115-30117

ХӨДӨӨ АЖ АХУЙН ШИНЖЛЭХ УХААН



Лааган Б. **Сарлагийн "нууц"-ад нэвтэрхүй**: Баримт, судалгаа, уламжлал, дурсамж / Хян. С.Ганбат; Эх бэлт. М.Гантогтох.- УБ.: Сэлэнгэ пресс, 2020.- 184х.- ISBN: 978-9919-20-092-3


Уг бүтээлд эрдэнэт таван хошуу мал сүрэг дотроос үхэр нэн ялангуяа сарлагийн гарал үүсэл, гэршиж гарын мал болсон үйл явц, амьдрахуйн онцлог, таваарлаг чанар, ашиг шим, түүнтэй холбоо бүхий түүх, соёл уламжлал, аман сурвалж, дурсамж тэр дундаа Монгол үүлдрийн бэлчээрийн сарлагийн дотоод ертөнц, онцлог, сарлагийн дуу авианаас эхлээд хэрэглээний тоног төхөөрөмжийн талаар дэлгэрэнгүй өгүүлэхийн сацуу сарлагийн бүтээгдэхүүний нэр томъёог хавсаргажээ.

46.0

Л 101

/БУУТ-3/

ЭШФ Б-30344-30346



Санжаадорж Н. **Хүлэгч хүлэгс** / Эх бэлт. С.Эвийнбилэг, Г.Хишигдэлгэр, Б.Нямдарь; Эрхл. Ж.Саруулбуян, А.Төмөр-Очир; Хян. Д.Даваа, И.Байгалмаа; Диз. Л.Энхтуяа.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 463х.- ISBN: 978-99973-3-860-0

Энэхүү бүтээлд Халх Монгол даяарыг хоёр зуугаад жилийн турш эзэгнэсэн хардал жанжин бэйсийн /эдүгээгийн хээр Галшарын/ их хурдны удам угшил, хуучин цагийн болоод эдүгээ цагийн хүлэгч уяачдын тухай сонирхолтой баримтуудыг өгүүлжээ.

46.11


С 311

ЭШФ Б-30350-30352

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААН

Ард түмэндээ амиа өргөсөн сувилагч Цогтын Магсар / Ред. А.Болдбаатар; Эмхт. Ж.Даваа; Эх бэлт. Б.Гүнцэрэн, Б.Гүндалай.- УБ., 2020.- 92х.- ISBN: 978-9919-20-195-1

Баянхонгор аймагт 1943 онд гарсан тарваган тахал өвчнийг устгах, голомтонд байсан 40 гаруй хүнийг эмчлэн сувилж байгаа өөрөө тахал өвчнөөр нас барсан сувилагч, баатарлаг үйлстэн Цогтын Магсарын гавьяаг мөнхжүүлэн хойч үедээ мэдүүлэх зорилгоор “Цогтын Магсар” нийгэмлэгээс энэхүү намтар эмхтгэлийг хэвлүүлжээ.



51.1(1)г
А 727

ЭШФ Б-30318-30320

НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН

Хишигтөгс А. **Хүнийсэл**: Өөртөө хөөгдсөн хүн.- УБ., 2020.- 500х.- ISBN: 978-9919-20-231-6

Энэхүү бүтээлд бидний бүтээж байгаа нийгэм эргүүлээд бидний бүтээж байдаг. Хэрэв хүмүүс хүнийсэлтэйгээр бүтээгдсээр байвал тэр нийгэм өвчилдөг төдийгүй нийгэм хүнийг хэрхэн хүнийсгэж харийн болгодог тухай өгүүлсний дээр мөн социологийн аргаар ний нуугүй шүүж судалгааны үр дүнг харуулахыг зорьжээ.



60.5
Х 377

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Б-30226-30228

ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН

Чингисийн чулууны бичгийн судалгаа: 200 жилийн түүх: Судлаач, бүтээл, тайлбар / Эмхт. Б.Түвшинтөгс.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 448х.- ISBN: 978-9919-9551-8-2

Энэхүү номд Чингисийн чулууны бичгийн тухай судалгаа шинжилгээний бүтээлүүдэд Чингис хааны ач дүү Есүнгэ ноёны хөшөөний бичиг, Хархираагийн хөшөөний бичиг гэх зэргээр тэмдэглэсэн монгол бичгийн одоогоор мэдэгдэж буй хамгийн эртний дурсгалыг нээж олсон түүх, судалж ирсэн байдал, уншиж тайлбарласан талаарх тойм болон 5 мөр 21 үгтэй уг цомхон дурсгалыг 200 жилийн туршид судалж сурталчилсан бүтээлүүдийн жагсаалтыг бүртгэн оруулсан ба түүнчлэн уг дурсгалыг судалсан зарим бүтээлийг эмхэтгэн оруулжээ.



63.2
Ч 63

/НХУУТ-3/

ЭШФ Т- 24497-24501

Ариунбайгаль Б. Гуулин улсын судар дахь Монгол-Солонгосын харилцааны бичгүүд / Ред. Б.Сумьяабаатар, Ц.Цэрэндорж.- УБ.: Соёмбо принтинг, 2021.- 227х.- ISBN: 978-9919-504-39-7



Тус номд өгүүлж буй “Гуулин улсын судар”-ын 1270-1280 оны хоорондох 540 орчим мэдээ баримтыг эрдэмтэн судлаачид шүүрдэн судалсны дотор Монгол-Солонгосын харилцаанд холбогдох 150 гаруй бичиг захидлыг олж, тэдгээр бичиг захидлыг төрөл хэлбэрээр нь ангилж, орчуулан, эрдэм шинжилгээний тайлбар зүүлт хийгээд, Монголын хаадын зарлигийн бичгийн хэлбэр төрөл, хэв маягтай харьцуулан судалсан судалгааг хамтатган энэхүү бүтээлд багтаажээ.

63.3-6
A 751

/НХУУТ-5/

ЭШФ Т-24372-24376



Гэрэлбадрах Ж. **Дунд үеийн Монголчуудын нэр, хоч, цол: VIII-XII зуун** / Эх бэлт. Д.Ганчимэг; Эрхл. Ц.Цэрэндорж.- УБ.: Адмон, 2020.- 167х.- ISBN: 978-9919-20-953-7

Энэхүү бүтээлд дундад эртний үеийн Монголын овог аймгуудын болон Монгол улсын (1130-1189) буюу түрүү төр улсын үед цол хэргэмийн эзлэх байр суурь бага, харин хоч нэр зонхилж байсан болон 1206 онд Чингис хааны байгуулсан Их Монгол улс бол төгөлдөржсөн төр улсын эхлэл болох агаад тэр үеэс төрийн үүрэг, зохион байгуулалт нарийсахыг дагаж цол олширч, эрх үүрэг нь

тодорхой болж ирсэн талаар дурджээ.

63.3(1)
Г 95

/НХУУТ-2/

ЭШФ Т-24521-24522



Монгол нутгийн зургийн судалгааны зарим асуудал: Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл / Эх бэлт. Д.Ганчимэг; Эрхл. Ж.Гэрэлбадрах.- УБ.: Адмон принт, 2020.- 174х.- ISBN: 978-9919-9634-2-2

Энэхүү бүтээлд 2020 оны Түүхийн тэнхимийн Их семинар (2020.1.17)-аар монголчуудын түүх, соёлын үнэт өвийн нэг болох нутгийн зургийн судалгааны зарим асуудлыг хөндсөний дээр Монголын улс, аймаг, хошуу, чуулган, харуул, өртөөний даавуу, цаасан дээр гараар үйлдсэн нутгийн зургийн судалгааг тусгажээ.

63.3(1)
М 692

/НХУУТ-2/

ЭШФ Б-30386-30387



Өвөр монголын орчин үеийн ван гүнгүүдийн тэмдэглэл: Өвөр монголын соёл түүхийн материал: Монгол бичгээр / Орч. С.Гүрэн.- Хөх хот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2015.- 447х.- ISBN: 978-7-204-13701-5

Энэхүү бүтээлд Өвөр Монголын Өмнөд хошууны засгийн ван гүнгүүдийн амьдрал, улс төр-нийгмийн үйл ажиллагааны тухай өгүүлжээ. Тухайлбал: Харчин Чин ван Гүнсээноров, Алаша ван Данзан, Сэнгэринчин, Пүнд ван Гончигсүрэн, Баарин Жүн ван

Саданамжилванпү, Ауханы Чин ван Лэрчиринчинванпү, Ауханы Бэйсийн ордон ба Дэ ван, Хорчин баруун гарын Өмнөд хошууны Утай вангийн урвалган, Далай Бэйс ба түүний хүү Дорж, Засаг ван Гүнгийн тэмдэглэл зэрэг түүхэн баримт мэдээлэлүүдийг фото зурагтайгаар оруулсан байна.

63.3(545)-28

Ө 67

ЭШФ Б-30160

Пүрэвдагва Н., Туяа С. **Будант жилүүдийн эмгэнэл буюу Лувсанцэрэнгийн Цэнд** / Ред. С.Туяа; Эх бэлт. П.Булга; Хавтасны зураг, диз. Б.Баярбаатар.- УБ.: Жиком пресс, 2021.- 236х.- ISBN: 978-9919-24-130-8



Энэхүү бүтээлд нам, төрийн дээд албан тушаалд хэдэн жил зүтгэсний эцэст нутаг заагдан, хатуу хяналт шалгалтын дор насыг барсан Лувсанцэрэнгийн Цэндийн эмгэнэлт хувь тавилангийн түүхийг өгүүлжээ.

63.3(1)-8

П 915

ЭШФ Т-24449-24450

Флипис Э.Д. **Монголчууд: Эх хаадын эзэнт гүрнийг үндэслэгчид** / Орч. Ч.Баатар, С.Одхүү.- Да Сва Тва, 2012.- 179х.- ISBN: 978-99929-0-762-0




Энэхүү бүтээлд Чингис хаан хэрхэн өргөмжлөгдөж Монгол гэдэг улс үндэстнийг хэрхэн удирдаж байсан мөн Монголчуудын өв соёл уламжлалын талаар дурдсаны дээр хүч чадлын уг сурвалж нь сахилга бат, зохион байгуулалт байсан талаар өгүүлжээ.

63.3(1)

Ф 72

ЭШФ Б-30155

Хятад пүүс Да Швэнг Күй: Монгол түүхийн дуран хараа.- Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2012.- 399х.



Энэхүү бүтээлд Чин улсын үеэс иргэн улсын анхны жилүүдэд хүртэл ар өвөр Монголын олон газраар худалдаа наймаа хийж байсан Хятадын томоохон пүүсийн талаар өгүүлсний дээр уг пүүс нь тамгат баримтын зээл тавихаар гол болгож адуу мал, арьс ноос, эмийн материал, өдөр тутмын хэрэглээний бүрэн бараа зэргийг худалдаалж байсан талаар дурджээ.

63.3(Хят)-2

Х 995

ЭШФ Б-30156

Халтар М., Мөнхбаяр Х. **Улаанбаатар дахь хэлмэгдэл ба цагаатгал** / Хян. Ж.Батбаясгалан, О.Лхагварэнцэн; Эх бэлт. Г.Ганчимэг.- УБ.: Эс Пи Ар, 2020.- 344х.- ISBN: 978-9919-24-165-0



Монгол улсад өрнөсөн улс төрийн их хэлмэгдүүлэлтийн үеэр Нийслэл хүрээнээс Улаанбаатарт хэлмэгдлийн хор уршиг хэрхэн дайран өнгөрсөн болоод Улаанбаатарт ажиллаж амьдарч байх үедээ хэлмэгдсэн улс төр-нийгмийн зүтгэлтнүүдийн тухай өгүүлжээ. Мөн цагаатгах ажлыг зохион байгуулсан нийслэл, дүүргийн салбар комиссын үйл ажиллагааны талаар дурдсан байна

63.3(1-2УБ)+66.3(1)6

Х 195

ЭШФ Т-24313-24315



Энхтайван Л. **Үргэлж хамтдаа** / Ред. А.Зандармаа, Хян. Т.Баасансүрэн, Э.Зосон; Хэвлэлд бэлт. Л.Энхтайван; Диз. П.Содбаатар.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 280х.

Энэхүү бүтээлд 50-60-аад оныхон гэгдэх бидний үе нийгмийн 2 тогтолцоо, хоёр зуунд ажиллаж амьдарсан, 1990 он хүртэлх бүтээн байгуулалт, хотжилт, 1990 оноос хойших ардчилал, зах зээлийн харилцааг бий болгоход биеэр оролцсоны хувьд нийгэм эдийн засгийн хүндрэл бэрхшээл, ололт амжилтын харьцуулалтын талаар мөн өөрийн ажил төрөл, мэргэжил, 46 жил ханилж амьдралын жаргал зовлонг туулсан хань Оюунбилэг нь хүнд өвчний улмаас таалал төгссөн ханийхаа тухай, аав ээж, үр хүүхэд, хамаатан садан, найз нөхөд болон хамтрагчдынхаа талаар дурджээ.

63.3(1)-8

Э 66

ЭШФ Т-23912-23913



Цэнд гүн ба Монголын нууц товчооны анхны монгол орчуулга / Удиртгал бичиж, хэвлэлд бэлт. Б.Түвшинтөгс; Эрхлэн хэвл. Д.Заяабаатар, Б.Ичинхорлоо; Эх бэлт. Т.Энхтунгалаг; Хавтасны диз. Э.Доржханд.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 400х.- ISBN: 978-9919-9551-7-5


Энэхүү бүтээлд уг орчуулга, сийрүүлгүүдийн хувь заяа, учир холбогдол, үнэ цэнийн талаар тодорхой дурдсанаас гадна Монголын нууц товчооны хятад утгачилсан орчуулгыг Цэнд гүн хэрхэн монгол хэлээр буулгасныг харуулах үүднээс эхийн гэрэл зураг, түүнийг кирилл үсэгт хөрвүүлэн тусгажээ.

63.3(1)

Ц 956

/НХУУТ-2/

ЭШФ Т-24462-24464



Дашдулам Д. **Өндөр гэгээний мутрын авшиг** / Хян. У.Сарантуяа; Орч. Кристина Телеки; Эх бэлтгэл диз. Ц.Солонго.- УБ.: Улаанбаатар принт, 2018.- 43х.- ISBN: 978-99978-867-8-1

Энэхүү бэсрэгхэн товхимолд Анхдугаар Богд Өндөр гэгээн Занабазарын мэндэлсэн цаг үеийн тухай домог яриа болоод манай музейн сан хөмрөгт буй түүний эдлэл хэрэглэлийн судалгаа, мөн гэгээнтний мутрын дардасны хэмжээсийг энгийн хүнтэй харьцуулсан судалгааны баримт сэлтийг монгол, англи хэл дээр бичсэн байна.

63.5(1)
Д 393

ЭШФ Б-30315-30317

Монгол нүүдэлчдийн тайлбар толь: 3 боть / Ерөн. ред. Г.Сүлд-Эрдэнэ.- УБ.: Монсудар, 2020.

63.5(1)я2
М 692




Б.1: Монгол гэр, хувцас, мал аж ахуй / Ред. Э.Уранбилэг, П.Оюунгэрэл, Н.Даш, Ч.Нямцэцэг; Техник ред. Б.Батцэцэг, Б.Одончимэг, Э.Пүрэвжаргал; Оролц. Л.Наранцэцэг, Д.Ариунхүү; Зураач Б.Гэрэлмаа, Ш.Галзагд; Эх бэлт. Ш.Лхамсүрэн, Б.Баясгалан.- 2 дахь хэвл.- 580х.- ISBN: 978-978-99973-1-817-6

Тус ботид монголчуудын гэр/өргөө гэр, эсгий туургатан гэр, монгол гэр, гэр барих цуцах, ачаалж нүүх, гэр гэрлэх/, хувцас/малгай, дээл, цамц, өмд, гутал/, мал ахуй/таван хошуу мал, эдлэл хэрэглэл, ажлын мөчлөг, ашиг шим /-н тухай хар болон өнгөт зурган дээр дэлгэрэнгүй тайлбарлажээ.

/НХУУТ-4, ГНОФ-4/

ЭШФ Б-30335-30337

Б.2: Цай, идээ, зоог шүүс /; Ред. Л.Навчаа, Б.Батцэцэг, Э.Уранбилэг; Техник ред. Н.Даш, П.Оюунгэрэл, Э.Пүрэвжаргал; Гэрэл зурагчин Б.Баясгалан; Зураач Б.Төрмөнх; Газарзүйч Г.Энхбаяр; Эх бэлт. Б.Бурмаа, Б.Баясгалан.- 480х.- ISBN: 978-99973-1-050-7



2-р ботид цай, цайны дээж, сүүтэй ба хээрийн цай, жимбүүр ба чин цай, хярам, идээ ундаа, цагаан идээ, үр тариа, амуу будаа, ургамал, мөөг, жимс, зоог шүүс, зум, шаруус, бүхэл ууц, өвчүүн шүүс, хорхог, тэвхэн ууцын тухай хар болон өнгөт зурган дээр дэлгэрэнгүй тайлбарлажээ.

/НХУУТ-4, ГНОФ-4/

ЭШФ Б-30338-30340

Б. 3: Баяр, наадам, найр / Ред. Б.Батцэцэг; Техник ред. Б.Одончимэг, Л.Навчаа, Ж.Хишигжаргал ба бус.; Гэрэл зурагчин Б.Баясгалан; Зураач Б.Төрмөнх; Зөвлөх ред. Ч.Нямаа, М.Одмандах; Эх бэлт. Б.Баясгалан, С.Батжаргал; Хавтасны зураг Б.Төрмөнх.- Анхны хэвл.- 434х.- ISBN: 978-99973-1-051-4



Монгол ёс заншил, монгол малчдын эрдэм, монголчуудын арга ухаан, өв соёлоо өөрсдийн ахуй амьдралд авч хэрэглэх, хөгжүүлэхийг зорьсон нийт уншигчдад зориулагдсан энэ цувралын 3-р ботид үндэсний уламжлалт баяр, наадам, найрын ёслолын талаар өнгөт зурагтайгаар дэлгэрэнгүй тайлбарлажээ.

/НХУУТ-4, ГНОФ-4/

ЭШФ Б-30341-30343

Нүүдэлчдийн өв судлал: Том. XXI-II, Fasc. 1-23 / Эрхл. Д.Сүхбаатар.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 256х.- ISBN: 978-99978-748-2-5



Монголын үндэсний музейгээс эрхлэн гаргадаг цуврал бичгийн энэ удаагийн хэвлэлд эртний археологийн дурсгал, булш, хадны зураг, бичээс, түүх судлалын баримтууд, угсаатан судлал, соёл урлаг судлалын эрдэм шинжилгээ судалгааны хэлэлцүүлэг, дүгнэлт, баримт бичгүүд багтсан байна.

63.5
Н 88

ЭШФ Т-24326-24327

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН



Монголын эдийн засгийн дэлгэрэнгүй тайлбар толь / Ерөн. ред. Т.Дорж, А.Бакей, Б.Батхишиг.- УБ.: Адмон, 2021.- 999х.- ISBN: 978-9919-20-936-0

Энэхүү тайлбар толь бичигт эдийн засгийн нэр томьёо, үг хэллэгүүдийн гарал үүсэл, тодорхойлолт, утга, ангилал, нөлөөлөх хүчин зүйлийн талаар цэгцтэй тайлбарлахын зэрэгцээ бүдүүвч, зураг, хүснэгт, математикийн тэгшитгэл, томьёог оруулснаар ойлгоход дөхөм болсон байна. Түүнчлэн эдийн засгийн шинжлэх ухааны хүрээнд багтах мөнгө, санхүү, төсөв, татвар, гааль, гадаад худалдаа, зээл тусламж, хөрөнгө оруулалт, өмч хөрөнгө, үнэ тариф, хөрөнгийн зах зээл, нягтлан бодох бүртгэл, менежмент, маркетинг зэрэг эдийн засгийн салбар шинжлэх ухааны олон ойлголтыг системтэй ойлгоход тус толь бичиг чухал ач холбогдолтой юм.

65(1)я2
М 692

/НХУУТ-6, БС-5, ЛавФ-1/

ЭШФ Т-24352-24354



Санхүүгийн нягтлан бодох бүртгэл I: Сурах бичиг / Ред. А.Өнөржаргал, Д.Нямаа.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2021.- 312х.- (МУИС).- ISBN: 978-9919-24-210-7

Санхүүгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналын онолын ойлголтууд, санхүүгийн байдлын ба орлогын дэлгэрэнгүй тайлан, Мөнгөн хөрөнгийн бүртгэл, мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн тооцоолол, түүнийг нягтлан бодох бүртгэлд хэрэглэх нь, Авлага, урьдчилж гарсан зардал ба урьдчилж төлсөн тооцооны бүртгэл, Бараа материалаарх хөрөнгийн бүртгэл, тайлагнал, Биет бус хөрөнгийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагнал, Богино хугацаат өр төлбөрийн бүртгэл, тайлагнал, Хувьцаат капиталын бүртгэл, Урт хугацаат өр төлбөрийн бүртгэл, тайлагнал, Хуримтлагдсан ашгийн бүртгэл, Өмчийн өөрчлөлтийн тайлан бэлтгэх арга зүй, Хөрөнгө оруулалтын бүртгэл, тайлагнал, Мөнгөн гүйлгээний тайлан ба санхүүгийн тайлагналын нэмэлт тодруулгыг бэлтгэх арга зүй гэсэн 12 бүлэг сэдвийг хамруулжээ.

65.052я73
С 324

/НХУУТ-4, ГНОФ-3, БС-10/

ЭШФ Т-24361-24363

Лхагважав Б. **Татварын онол, оновчлол загварчлал** / Хян. Н.Тунгалаг.- УБ.: Хас дизайн пресс, 2020.- 170х.- ISBN: 978-9919-20-022-0

Энэхүү бүтээлд татварын онол, аргазүйг оновчлолын онолын үүднээс авч үзсэн төдийгүй орчин үед татварын онол нь бүхэлдээ оновчлолын онол дээр суурилсан гэдгийг онцлон харуулсан. Мөн татварын онол, Монгол улсын татварын хөгжил, шинэчлэл, төлөвшил, бүртгэлд суурилсан татварын шинэчлэлийн асуудлын талаар тусгажээ.

65.261.4

Л 874

/НХУУТ-9, ГНОФ-8, БС-5/

ЭШФ Т-23971-23973



Коносүкэ М. **Бизнесийн амжилт хүнээс**: Бизнес дэх хүний хүчин зүйл / Ред. Ж.Оюунчимэг; Орч. Ч.Ундрам; Эх бэлт. Д.Энхнаран.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 120х.- ISBN: 4-596-53704-9

Тус бүтээлд байгууллагын амжилт нь хүний нөөцөөсөө хамааран тодорхойлогддоггоос гадна бизнесийн өсөлт нь ажилтнаас ихээхэн шалтгаалдаг бөгөөд шаардлагатай ажлыг гүйцэтгэх ур чадвартай хүн байгаа эсэхээс шууд хамаарна. Хичнээн гайхамшигтай арга барил, байгууллагын соёл шилдэг технологи, үйлчилгээ нэвтрүүлсэн ч эдгээр талыг нь өндөр хэмжээнд, тогтвортой байлгах ур чадвартай нөөцгүй бол бизнес аажимдаа мөхнө. Тиймээс бизнесийн байгууллагууд хүний нөөцийн хөгжлийн асуудал болох сонгон шалгаруулалт, сургалт хөгжил, ажилчдынхаа авъяас чадварыг бүрэн ашиглах асуудлыг чухалчлан авч үзжээ.

65.290-2

К 647

ЭШФ Т-24440-24442



Уянга Г. **Байгууллагын шударга ёс** / Өмнөтгөл үг тэрлэсэн Я.Долгоржав.- УБ., 2021.- 129х.

Уг бүтээлдээ зохиолч “Байгууллагын шударга ёс” гэх тодорхой нэгэн сэдвийн хүрээнд уншиж судалсан мэдлэг, өөрийн олж тогтоосон баримт, мэдээлэлдээ шинжлэх ухааны арга, аргазүйн дагуу боловсруулалт хийсэн судалгааны ажил дээр үндэслэсний дээр шударга ёс гэдэг ерөнхий концептуал ойлголтыг тодорхой байгууллагын түвшинд буулган улмаар түүнийг хэрхэн хэмжиж болох тухай асуудлын талаар авч үзжээ.

65.290

У 711

/НХУУТ-4, ГНОФ-3, БС-5/

ЭШФ Т-24349-24351



Шүрэнцэцэг Б. **Суралцагч байгууллагын хөгжил**: Онол, арга зүй / Ред. Г.Батхүрэл; Эх бэлт. Ш.Ариунаа.- УБ.: Нью Индиго, 2020.- 245х.- ISBN: 978-9919-24-093-6

Уг бүтээлд Монголын худалдааны компаниудын хөгжлийн зорилго, зорилтууд болон сургалт, хөгжлийн асуудлыг суралцагч байгууллагын шалгуураар үнэлсэн төдийгүй энэ талаарх гадаадын компаниудын туршлагыг харьцуулан судалж ололт, амжилтыг нэгтгэн дүгнэсэн дүгнэлт, суралцагч байгууллагын загвар, хөгжлийн үнэлэх арга зүйг боловсруулан арга зүйгээ Худалдааны компаниудад



туршин, хэрэгжүүлэх боломжтойг нотолж, мөн үүнтэй уялдаатай заавар, зөвлөгөөг давхар тусгажээ.

65.290
Ш 962

ЭШФ Т-24437-24439



Өнөржаргал Ц. Удирдахуйн ухаан 50 менежмент, менежер бүрийн ширээний ном.- УБ.: 2020.- 547х.

“Удирдахуйн ухаан” хэмээх энэ бүтээлд асуудлын гарцыг хайсан менежментийн 50 сонгомол аргыг ойлгомжтой, сонирхолтой хэлбэрээр бичжээ. Уг бүтээл нь Менежментийн үндэсний зөвлөх, Удирдлагын акадემийн ахлах багш Ц.Өнөржаргалын арав гаруй жил хийсэн судалгааны эмхэтгэл бөгөөд “Удирдахуйн ухааныг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд хэвлэгдэж буй эхний бүтээл нь юм.

65.290-2
Ө 83

/БС-1/

ЭШФ Т-23987-23989



Эрдэнээ О., Галсандорж Д. Зууны манлай Эрдэнэт үйлдвэрийн түүхэн хөгжил: Өнгөрсөн, одоо, ирээдүй / Ерөн. ред. П.Очирбат; Гэрэл зур. Д.Галбаатар, Ц.Батбаатар, Д.Галсандорж.- УБ.: Адмон, 2020.- 187х.- ISBN: 978-9919-20-547-8

Уг бүтээлд Монгол улсын их бүтээн байгуулалтын он жилүүдийн үлгэр жишээ болсон уул уурхайн томоохон үйлдвэр уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр ашиглалтад ороод үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш эдүгээ 42 дэх жилтэйгээ золгож байгаа төдийгүй манай орны уул уурхайн салбарын хөгжлийн түүхээ мөн

болох талаар тусгажээ.

65.304.11(1-M20)
Э 739

ЭШФ Т 24321-24322



Худалдааг хөнгөвчлөх нэр томъёоны англи-монгол тайлбар толь бичиг=English-Mongolian glossary of trade facilitation terms.- УБ., 2020.- 304х.

Энэхүү тайлбар толь бичигт аль ч улс оронтой хийх худалдаа арилжааг хөнгөвчлөх зорилгоор байнга ашиглагдах үг хэллэг болон нэр томъёог тусгажээ.

65.42я2
Х 667

/НХУУТ-4/

ЭШФ Т-24338-24340

Худалдааны бодлогын нэр томъёоны тайлбар толь бичиг / Хян. Н.Отгонсайхан; Орч. Д.Сэнгэлмаа.- УБ.: Интерпресс, 2020.- 414х.- ISBN: 978-9919-20-651-2

Энэхүү толь бичигт худалдааны бодлогын үндсэн нэр томьёо төдийгүй ДХБ-ын болон худалдааны бусад олон талт хэлэлцээрүүд, тэдгээрийн хүрээнд гишүүн орнуудын хооронд үүссэн зарим гол маргааныг шийдвэрлэсэн тохиолдол, бүс нутгийн худалдааны хэлэлцээрүүдийг хамруулснаас гадна хөдөө аж ахуй, нэхмэл сүлжмэл, тээвэр, хөрөнгө оруулалт, үйлчилгээ, оюуны өмч, санхүүгийн зэрэг салбарын худалдааны бодлого болон салбар дундын бодлогын асуудал, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах бодлого зохицуулалтын талаар 1500 гаруй нэр томьёог тусгажээ.



65.42я2


X 667

/НХУУТ-5, ГНОФ-7, БС-5/

ЭШФ Т 24341-24343

Гантөмөр Д. **Жуулчны зорих газрын менежментийн төлөвлөгөө:** Онол, стратеги, кэйс / Эх бэлт. Э.Ганхуяг.- УБ., 2019.- 176х.- ISBN: 978-99978-68-49-7

Энэхүү бүтээлд аялал жуулчлал гэж юу болох, түүний нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх эерэг, сөрөг нөлөө, аялал жуулчлалын суурь нөхцөл, нөөцүүдийн тухай өгүүлж монгол оронд аялал жуулчлал хөгжүүлэх бодлого, үйл ажиллагааны өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ Дорноговь аймгийн Их нартын байгалийн нөөц газарт хийсэн судалгаанд үндэслэн өгүүлжээ.



65.433(1-M6)

Г 21

ЭШФ Б-30392

Гантөмөр Д. **Монгол улсын аялал жуулчлалын хөгжилт:** Судалгааны эмхэтгэл / Зөвлөх Г.Чулуунбаатар; Ред. Г.Өлзийсайхан; Техник ред. Д.Энхцэцэг.- УБ.: Шинэпресс, 2019.- 250х.- ISBN: 978-99978-67-19-3

Уг бүтээлд аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах бодлого, стратегийн удирдлага, төлөвлөлтийн багц асуудлыг орчин үеийн онол, арга зүйн үүднээс авч үзсэний дээр Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилтуудыг аялал жуулчлалын өрсөлдөх чадвартай хэрхэн холбогдож буй онол, практикийн асуудлууд Монголын аялал жуулчлалыг хөгжүүлэх ерөнхий загвар, түүний өвөрмөц онцлог хийгээд аялал жуулчлалын бүс тойрог байгуулах, монголын бренд болохуйц аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох, боловсон хүчин бэлтгэх, дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг олон асуудал дээр зохиогч өөрийн байр суурь, санал зөвлөмж, тодорхой баримт жишээтэйгээр тусгасан байна.



65.443(1)

Г 21

ЭШФ Б-30391

Дүгэржав Д. **IPO Гарын авлага** / Хян. С.Сүрэнхүү.- УБ., 2019.- 99х.- ISBN: 978-9919-22-717-3



Өмгөөллийн ЭмДиЭс энд Хаанлекс ХХН-ийн партнер, хуульч Д.Дүгэржавын боловсруулсан энэ бүтээлд IPO гэж юу болох, түүний давуу болон сул талууд, IPO олон нийтэд гаргах үйл явц, анхаарах зүйлс зэрэг IPO-ийн талаар сонирхон судалж буй хэн бүхэнд хэрэгтэй мэдлэг олгох агуулгыг багтаасан болно.

65.9(1)-56я7

Д 744

/НХУУТ-3, ХЗС -3/

ЭШФ Б-30178-30179

УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН



Алтай Д. **Хөршийн харилцаа, Орос-Европ судлал:** Өгүүлэл, илтгэл, ярилцлага.- УБ.: Удам соёл, 2020.- 344х.- ISBN: 978-9919-20-291-0

Зохиолч товхимолдоо сүүлийн жилүүдэд Евроази, Орос судлалын чиглэлээр монгол болон гадаад хэлээр туурвисан хорь гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, ярилцлагаа оруулсан байна. Мөн түүний үүсгэн байгуулсан эрдэм шинжилгээ, соён гэгээрлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй "Төв ба Зүүн Европ судлалын Монголын холбоо" ТББ-ын шугамаар зохион байгуулсан эрдэм

шинжилгээний хурлын илтгэлүүд, сэтгүүл, товхимолд орсон гол материалуудыг багтаажээ.

66.4

А 485

/НХУУТ-4, ОУХНУС-5/

ЭШФ Б-30329-30331



Баясгалан С. **Олон улсын аюулгүй байдал ба Монгол улсын цөмийн зэвсгээс ангид статус.**- УБ.: Удам соёл, 2017.- 161х.- ISBN: 978-99978-1-397-8.

Цөмийн зэвсэгтэй улс орнуудын өнцгөөс харж цөмийн зэвсгээсээ татгалзахаас нааш олон улсын аюулгүй байдалд цөмийн зэвсгийн аюул хэвээрээ байна. Тиймээс цөмийн зэвсэггүй Монгол улс олон улсын харилцааны нэг субъектын хувьд биднийг тойрохгүй, уг аюулд тодорхой хэмжээгээр өртөх боломжтой учраас Монгол улс цөмийн зэвсэггүй бүс болох асуудлыг олон улсын харилцааны орчинд

тулгуурлан тайлбарлажээ.

66.4(0)

Б 377

/ОХНУС 5564-5573/



Дашпүрэв Д. **Монголын нийгмийн модернизацийн үе шатууд= Этапы модернизации Монгольского общества:** Нийгэм-философийн анализ.- УБ., 2021.- 408х.- ISBN: 978-9919-24-119-3

Энэхүү бүтээлд тухайн цаг үеийн дан ганц улс төрийн, конъюнктүр зорилт өмнөө тавиагүй бөгөөд дэлхий дахины түүхэн хөгжилд Монгол улсын эзлэх байр суурь, гүйцэтгэдэг үүргийг тодорхойлон тодруулж, үндэснийхээ тусгаар тогтнол, төр улсын бие даасан

байдлыг байлдан олж, хадгалж үлдэхийн төлөө, соёлынхоо давтагдашгүй өвөрмөц байдлыг хэвээр байлгахын төлөө хийж ирсэн тэмцлийн бүхий л ахиц дэвшил, ээдрээ, бартаа саадыг өгүүлжээ.

66.2(1)

Д 392

/НХУУТ-3/

ЭШФ Т-24491-24493

Зүмбэрэллхам Д. **Төрийн алба**: Шинэтгэлд шимтэхийн учир: Илтгэл, өгүүлэл, ярилцлага, нийтлэл / Эмхт. А.Булгаа, Б.Гончигсумлаа; Технологич инженер С.Ууганзаяа; Эх бэлт. Х.Ганхөлөг.- УБ.: Ган зам пресс, 2020.- 312х.- ISBN: 978-9919-20-830-1

Энэхүү бүтээлд номын зохиогч Д.Зүмбэрэллхамын төрийн албаны шинэтгэлийн талаар сүүлийн жилүүдэд бичсэн эрдэм шинжилгээний өгүүллүүд, хурал зөвлөгөөнүүдэд тавьсан илтгэл, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд өгсөн ярилцлага тэргүүтнийг багтаажээ.



66.3

З 909

/НХУУТ-2, ХЗС-10, ОУХНУС-5/

ЭШФ Т-24355-24357

Монгол ардын намын түүх / А.Алтанбагана, З.Баасанжав, Ж.Болдбаатар ба бус.; Эмхтгэн хян. Д.Амарбаясгалан, Б.Даш-Ёндон, Х.Сайхансанаа, Д.Цэвээндорж; Эх бэлт. П.Түмэнцэцэг, Ш.Адьяа, Г.Чулуун-Үрэл; Диз. Т.Мөнхдэлгэр, Ч.Мөнхжаргал, Д.Даваасүрэн.- Нэм.засв. 2 дахь хэвл.- УБ., 2021.- 1415х.- ISBN: 978-9919-24-296-1

МАН-ын 100 жилийн ойд зориулан бүтээсэн энэхүү бүтээлд өмнө нь гарсан 9 ботио нэгтгэн баяжуулж нэг номонд багтаан гаргасан байна. Монгол ардын намын түүх нь Монголын нийгмийн амьдралын бүхий л салбарын хөгжил, ололт амжилт, алдаа оноотой бүхэнтэй салшгүй холбогддог билээ. Тус номонд XX зууны эхэн үеийн Монгол орон, Намын зохион байгуулалтын бэхжилт, Социализм байгуулах оролдлого, түүний үр дагавар, Дэлхийн 2-р дайн ба Намын бодлого, үйл ажиллагаа, Дайны дараахь ОУ-ын харилцаа, Нийгмийн шинэчлэл, зөрчил бэрхшээл, МАХН-ын удирдлага, дотоод асуудал, Төрийн удирдлагад гарсан өөрчлөлт, МАХН-ын Онц их хурал, Нийгмийн шилжилтийн үеийн намын бодлого, үйл ажиллагаа зэрэг өргөн агуулгыг багтаажээ.



66.6(1)

М 692

/НХУУТ-2/

ЭШФ Т-24332-24334

Монгол ардын намын түүхэн цаг хугацааны товчоон: Тусгаар тогтнол-хөгжлийн зуун / Ред. зөвлөл. У.Хүрэлсүх, Д.Амарбаясгалан; Нарийн бичгийн дарга Х.Сайхансанаа; Гишүүд Б.Баярбаатар, Н.Энхбаатар, Д.Сандаг-Очир ба бус.; Эх бэлт. Д.Дүнчигмаа, Б.Баасанжаргал; Диз. Т.Мөнхдэлгэр, Ж.Түмэн-Өлзий, О.Мягмардорж, О.Чинбат; Орчуулгын зөвлөл О.Энхцэцэг, Р.Баасан, Ц.Батбаяр ба бус.- Анхны хэвл.- УБ., 2021.- 531х.- ISBN: 978-9919-24-300-5.



Тус бүтээлд 1907-2020 оны хооронд МАН-ын түүхэнд холбогдох үйл явдал ба түүхт хүмүүсийн тухай мэдээллийг он цагийн дараалалд оруулан фото зураг, тоо баримттайгаар монгол-англи хэлээр тодорхой өгүүлсэн байна.

66.6(1)

М 692

/НХУУТ-2/

ЭШФ Т 24335-24337



Хурметхан М. **Монгол улс, Америкийн нэгдсэн улсын харилцаа: Иж бүрэн түншлэлээс стратегийн түншлэлд: 2007-2020 он** / Хян. Ц.Батбаяр.- УБ., 2020.- 224х.- ISBN: 978-9919-96-39-03

2007-2020 онд Монгол Улс, АНУ-ын 2 талын харилцааны хүрээнд улс төрийн яриа, хэлэлцээг бүхий л түвшинд тогтмолжуулан идэвхтэй явуулж, өндөр, дээд хэмжээнд айлчлал хэрэгжүүлэн, эдийн засгийн хамтын ажиллагааны асуудалд түлхүү анхааран соёл, хүмүүнлэгийн харилцааг идэвхжүүлэхийг урьдын адил чухалчлан ажиллаж ирсэн талаар уг бүтээлд дурджээ.


66.4(1)

Х 728

/НХУУТ-3, ОУХНУТ-5/

ЭШФ Б-30161-30162

ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН



Монгол-Ойрадын цаазын бичиг / Харьцуулан тайлбарласан Э.Буян-Өлзий.- Хөх хот: Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2000.- 400х.- ISBN: 7-204-04577-7

Монгол-Ойрадын цаазын бичиг гэх уг бүтээл нь монгол үсгийн эртний бичлэгийн онцлогыг нилээд хадгалсан цаазын бичиг болно. Энэхүү бүтээлд Ойрад-Монголын хууль цааз, Өвөр монголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн түүх судлах газрын Цойжийн хадгалж байсан Диликүв худан монголд буулгасан орос орчуулгатай Их цаазын бичиг, Монгол хэл бичгийн сэтгүүлийн 1982 оны 4 дүгээр хугацаанд худан монголд буулгасан Ойрадын их засаг, Өвөр монголын ардын хэвлэлийн хорооноос 1985 онд хэвлүүлсэн Дорнотивийн харьцуулан тайлбарласан Ойрад цааз зэргийг багтаажээ.

67.3

М 692

ЭШФ Б-30159



Товуусүрэн Ц. **Үндсэн хуулиа ойлгохуй**: Үндсэн хуулийн хялбаршуулсан тайлбар: Монгол улсын анхны байнгын ажиллагаатай парламентын 30 жилийн ойд зориулав / Ред. Д.Лүндээжанцан; Эх бэлт. Г.Баатар.- 2 дахь хэвл.- УБ., 2020.- 209х.- ISBN: 978-99978-09-02-5

Энэхүү бүтээлд үндсэн хуульд 1999, 2000, 2019 онд оруулсан нэмэлт өөрчлөлтийн учир шалтгаан, тэдгээрийн зүйл хэсэг, заалт бүрийн задаргаа тайлбар, ер нь Үндсэн хууль цаашид хэрхэн задарч, дэлгэрч улс орныхоо амьдралын бүхий л харилцааны эрх зүйн зохицуулалтын үндсийг нээж байгаа талаар ойлгомжтой байдлаар тусган харуулжээ.

67.400.1

T 406

/НХУУТ-3, ХЗС-10/

ЭШФ Т-24018-24019

Банзрагч Г. **Захиргааны процессын эрх зүй** / Хян. П.Одгэрэл, М.Батсуурь.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 376х.- ISBN: 978-9919-22-620-6



Энэхүү бүтээл нь маш чамбай харьцуулсан судалгааны бүтээл. Учир нь Монгол улсын захиргааны процессын эрх зүйн зохицуулалтуудыг ХБНГУ-ын захиргааны процессын эрх зүйн зохицуулалттай харьцуулан авч үзэж, түүгээр зогсохгүй тус улсын олон тооны ном зохиол, эх сурвалжид хандаж, ашиглажээ. Харьцуулалтын үр дүнд өөрийн улсын эрх зүйн зохицуулалтын онцлог болон давуу талыг нээн илрүүлж, үүний зэрэгцээ цаашид засаж сайжруулахад хэрэг болохуйц бусад улсын туршлага, захиргааны процессын эрх зүйн уламжлалт нэр томъёо, ойлголтуудын талаар тусгажээ.

67.401

B 258

ХЗС-21979-21983

Гэрч, хохирогчийн аюулгүй байдлын онол, практикийн асуудал: Нэг сэдэвт бүтээл / Хян. Б.Эрдэнэбат; Техник ред. Э.Нэргүй, Ч.Энхбаатар.- УБ.: ДХИС-ийн хэвлэх үйлдвэр, 2021.- 221х.- ISBN: 978-9919-24-279-4



Энэхүү бүтээлд гэрч болон хохирогчийн аюулгүй байдал, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, нотлох, гэмт этгээдийн гэм бурууг тогтоох, шударга ял оногдуулах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх төрийн бодлого, хууль тогтоомжоор зөвшөөрсөн арга хэрэгслээр хангах, хамгаалах болон төрийн үндсэн чиг үүргийн талаар тусгажээ.

67.401.213

B 332

/НХУУТ-3, ГНОФ-4/

ЭШФ Т-24443-24445

Эрдэнэбаатар Д. **Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын системчлэл** / Хян. Б.Бат-Эрдэнэ; Хэвлэлийн эх, хавтасны диз. Л.Одхүү, Б.Жамсран.- УБ.: ДХИС-ийн хэвлэх үйлдвэр, 2021.- 223х.- (Монгол Улсын Дотоод Хэргийн Их Сургууль).- ISBN: 978-99978-68-39-8



Зохиолч энэхүү бүтээлдээ цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын хэрэгжилтэнд шинжилгээ хийж, цаашид журам боловсруулах, системчлэх, түүнийг кодификацилах ажлыг улам боловсронгуй болгох талаар асуудал дэвшүүлсэн байна.

67.401.213

Э 739

/НХУУТ-3, ГНОФ-4/

ЭШФ Т-24446-24448



67.404.2

Г 954

Гэрээний загварууд / Хян. С.Энхцэцэг; Хэвлэлд бэлт. Б.Сондор, Э.Номингоо, О.Эрдэнэдалай; Диз. О.Гомбо-Эрдэнэ.- УБ., 2020.- 228х.- (МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр).

Тус эмхтгэлд гэрээний эрх зүйг харилцааны шинжээр нь 7 төрөлд ангилан, харилцагч талуудын эрх ашгийг тэнцвэртэй тусгаж, хуульд заасан хэлбэр шаардлагад нийцүүлэн бэлтгэсэн 48 гэрээний загварыг оруулжээ. Оюутан судлаач, бизнес эрхлэгчдэд чухал гарын авлага болно.

ЭШФ Т 24301-24302



Энхбат А., Янжинсүрэн Г. Төрийн /нийтийн/ төсөв, санхүүгийн хяналт шалгалт: Онол, практик, арга зүй, тогтолцоо, эрх зүйн орчин / Эх бэлт. Л.Энхтайван.- УБ.: 2020.- 368х.- ISBN: 978-9919-20-605-5

Уг бүтээл нь төрийн нийтийн төсөв санхүүгийн хяналт шалгалтын онол, арга зүй, эрх зүйн орчин, төсвийн эрх зүйн онол аргазүй, төрийн санхүүгийн хариуцлага, төрийн санхүүгийн хяналт шалгалтыг явуулах үе шат, төрийн санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх арга зүй, төрийн нийтийн төсөв санхүүгийн хяналт шалгалтын тогтолцоо, харьцуулсан судалгаа, практик дүн шинжилгээ, олон улсын аудит төрийн хяналт шалгалтын байгууллагын тогтолцоо, түүхэн хөгжлийн чиг хандлага зэрэг хэд хэдэн бүлгийн хүрээнд авч үзсэн байна.

67.402

Э 66

/НХУУТ-4, ГНОФ-3, ОУХНУС-5/

ЭШФ Т-24358-24360



Иргэний хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ: Судалгааны тайлан.- УБ.: Мөнхийн үсэг, 2012.- 140х.- ISBN: 978-9919-24-374-6

Уг судалгааны ажлын тайланд түрээсийн гэрээ, тээвэр зуучийн гэрээ, холимог гэрээ, хүчин төгөлдөр бус гэж тооцож болох хэлцэл ба гэрээний чөлөөт байдлын зарчим, барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангахтай холбоотой маргаан, арилжааны шинжтэй гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахтай холбоотой маргаан, арилжааны шинжтэй гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахтай холбоотой маргаан, арилжааны шинжтэй гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахтай холбоотой маргаан зэрэг гол төлөв 3 шатны шүүхээр хянагдаж, шийдвэрлэгдсэн Дээд шүүхийн тогтоолуудад хийсэн дүн шинжилгээ багтжээ.

67.404

И 788

ХЗС-21984-21986

Оюу толгой: Хөрөнгө оруулалтын гэрээ / Ред. Ж.Алтантуяа; Эмхт. С.Баярцогт; Эх бэлт. Д.Цэрэндулам; Диз. Н.Бямбацогт.- 2 дахь хэвл.- УБ.: Нэпко, 2020.- 1203х.- ISBN: 978-9919-500-40-5

Энэхүү бүтээлд гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилгоор авч хэрэгжүүлсэн бодлого, Оюу толгойн гэрээнүүд, УИХ-ын баталсан хууль, тогтоол, хуралдааны тэмдэглэл, засгийн газрын тогтоол, тэмдэглэл, ерөнхий сайдын захирамжууд, шинжээчийн дүгнэлтэд өгөх хариу тайлбар, үүсэх эрсдэл, Оюу толгойн бүтээн байгуулалттай холбоотой тоо баримт, мэдээлэл, ярилцлагууд орсон байна.

67.404.2

О 63

/НХУУТ-6/

ЭШФ Т-24367-24369



Хуульд зааснаар болон зөрчлийн улмаас үүсэх үүрэг ба иргэний хуулийн хэрэглээ: Сургалтын гарын авлага / Хян. Х.Сонинбаяр; Эмхт. Ц.Соёлмаа.- УБ.: Эм Жи Эл дизайн, 2020.- 144х.

Энэхүү бүтээлд иргэний хуулийн 51-52 дугаар бүлэг хуульд зааснаар болон Зөрчлийн улмаас үүсэх үүрэг ба иргэний хуулийн хэрэглээ сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан арга хэмжээн дээр хэлэлцсэн асуудлын талаар тусгажээ.

67.404я7

Х 758

ЭШФ Т-24525-24527



Япон улсын хэрэглэгчийн гэрээний тухай хууль=Consumer contract act (Japan): Орчуулга, товч тайлбар=Translation and brief commentary / Ред. Б.Ундрах; Эх бэлт. Т.Энхтунгалаг; Хавтасны диз.Ч.Амарзаяа; Орч. Р.Пүрэвбаатар.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 175х.- ISBN: 978-9919-20-384-9

Энэхүү бүтээлд хамгийн сүүлд 2018 оны 06 сарын 15 (Хэйсэйгийн 30 он, хууль, Дугаар 54)-ны өдрийн байдлаар орсон нэмэлт, өөрчлөлтийг багтаасан бөгөөд Япон улсын Иргэний хуулийн 2017 оны нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор тус хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг мөн хамарсан болно.

67.404.2(5Яп)

Я 701

/НХУУТ-3, ХЗС-20/

ЭШФ Б-30211-30212



Давааням Г. Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд / Эх бэлт. Л.Энхтайван; Диз. Л.Энхтайван.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 144х.- ISBN: 978-9919-20-505-8

Энэхүү бүтээлд компаний хууль эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, холбогдох хуулиудын зарим заалтуудын мөн чанар хэрэглээг Америк, Япон, Сингапурын эрх зүйн орчинтой харьцуулан судалж, асуудал дэвшүүлэн шийдвэрлэх арга зам эрэлхийхийг зорьжээ.

67.406

Д 121



ХЗС-21939-21958



Давааням Г. **Хувьцаат компанийн эрх зүйн үндсэн ойлголт** / Ред. Б.Амарсанаа; Зөвл. И.Идэш; Эх бэлт. О.Болор; Хавтасны диз. Э.Мөнхтөр.- УБ.: Соёмбо принтинг, 2021.- 260х.- ISBN: 978-9919-24-494-1

Тус бүтээлд хувьцаат компанийн үүсэл хөгжлөөс эхлээд өнөөг хүртэл онолын үндсэн ойлголтыг системтэйгээр тайлбарласны дээр Монгол улс дахь хувьцаат компанийн эрх зүйн хөгжил, өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй 2011 оны Компанийн тухай хуулийн зохицуулалтын онолын ойлголт, практик хэрэглээ мөн хувьцаат компанийн эрх зүйн зохицуулалтын суурь үзэл санааг тайлбарлаж, шүүхийн практикт гарч буй хэрэг маргаан, хувьцаат компанийн үндсэн ойлголт нь зөвхөн компанийн тухай хуулиар хязгаарлагдахгүй бөгөөд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хуулийн хэлхээ холбоон дээр тогтдог тул холбогдох салбарын хууль дахь ойлголтыг тусгажээ.

67.406я73

Д 121

ХЗС 21987-22016



Дүгэржав Д. **Арбитрын тухай хуулийн товч тайлбар**. УБ., 2017.- 198х.- ISBN: 978-99978-0304-7


Уг бүтээлд УИХ-ын 2017 оны 1-р сарын 26 -ны өдрийн нэгдсэн чуулганаар батлагдсан Арбитрын тухай хуулийн шинэчлэл мөн хуулиар эрх зүйн маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх энэхүү аргын талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор уг хуулийн зүйлчилсэн товч тайлбарыг бичиж зүйл, хэсэг, заалт бүрийн агуулгыг хэрхэн ойлгох, Монгол улсын бусад хуулиудтай хэрхэн уялдаж байгаа талаар тусгажээ.

67.410

Д 744

/НХУУТ-3, ХЗС-2/

ЭШФ Т-24016-24017



Тэмүүлэн Б., Тайван А. **Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ**.- УБ., 2020.- 76х.

Шүүх өөрийн гаргаж буй шийдвэрээ олон нийт иргэдэд ойлгомжтойгоор, логиктой тайлбарлах үүрэг хүлээнэ. Иймээс энэхүү хууль ёсны зарчим Монгол Улсын Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд хэрхэн туссан талаар тус эмхэтгэлд тайлбарласан байна.

67.410

Т 896

/ХЗС 21851-21880/

Монголын олон улсын арбитрын шийдвэрийн түүвэрлэсэн эмхэтгэл: 2012-2019 / Эх бэлт. Н.Батдорж, Б.Золзаяа, Б.Сондор, Б.Хатантуул; Диз. О.Гомбо-Эрдэнэ.- УБ., 2020.- 364х.

Энэхүү шийдвэрийн эмхтгэлд маргаан шийдвэрлэх ажиллагаа, олон улсын арбитрын ажиллагааны талаар сонирхон судалдаг эрдэмтэн судлаач, оюутнуудад зориулан 2012-2019 оны хооронд шийдвэрлэсэн хэргүүдээс түүвэрлэн 48 хэргийн шийдвэрийг оруулжээ.

67.410(1)

М 692

ЭШФ Т-24303-24304



Монгол улсын нотариат: 2 боть / Дизайнер Д.Баттулга.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- (Монголын Нотариатчдын Танхим).

Монголын нотариатчдын танхимаас албан ёсоор эрхлэн хэвлүүлж буй энэхүү 2 боть бүтээлийн эхний ботид нотариатийн байгууллагын үүсэл хөгжил, бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, гадаад харилцаа, хамтын ажиллагааны түүх, Монголын нотариатчдын танхим, түүний салбар, гишүүдийн танилцуулга, дурсамж, 2-р ботид Нотариатын байгууллагын үйл ажиллагаанд хамаарах дүрэм журам ба гэрчлэн, баталгаажуулах ажиллагаанд хамаарах эрх зүйн баримт бичгүүдийг эмхтгэн оруулжээ.



67.410

О 356

Б. I: Онончимэг Р. Нотариатын байгууллагын түүхэн товчоон / Ерөн. ред. В.Оюумаа; Редакцийн зөвл. Н.Дашдорж, Д.Эрдэнэчулуун, А.Оюунчимэг ба бус.; Хэвлэлд бэлт. А.Золбоо; - 383х.

ЭШФ Т-24537-24539

Б. II: Нотариатын байгууллагын хууль тогтоомжийн эмхтгэл / Эмхт. Р.Онончимэг; Редакцийн зөвл. Ц.Энхбадрал, Ц.Энхтуяа, Ч.Эрдэнэбаяр; Хэвлэлд бэлт. Э.Мягмарнаран.- 352х.

ЭШФ Т-24540-24542



Оюумаа В. Олон улсын хувийн эрх зүйн зарим асуудал / Хян. С.Нарангэрэл; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Соёмбо принтинг, 2013.- 462х.

Энэхүү бүтээлд Нэгдсэн үндэстний байгууллагын ерөнхий ассамблейн 59 дүгээр чуулганаар баталсан төр ба тэдгээрийн өмчийн шүүхийн шүүн шийдвэрлэлтийн дархан эрхийн тухай НҮБ-ын конвенцид нэгдэн орох явдал зайлшгүй чухал болох, Монгол улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилгоор санал болгосон хэд хэдэн эрх зүйн хэм хэмжээний цогц, онолын зарим дүгнэлтүүдийг тусгажээ.

67.412.2

О 633

/НХУУТ-3/

ЭШФ Б-30395-30396



Оюумаа В. **Олон улсын эрх зүйн тайлбар толь** / Ред. Н.Хүрэлбаатар.- УБ., 2013.- 348х.

Энэхүү тайлбар тольд олон улсын эрх зүйн түгээмэл нэр томъёог тайлбарлахын сацуу судалвал зохих зарим олон улсын гэрээг хавсарган оруулсан байна.

67.412я2
О 633

/НХУУТ-3/

ЭШФ Б-30397-30398



Баярхүү Б. **Бэлгийн маргаантай асуудал: Шүүх эмнэлгийн магадлан шинжилгээ: II дэвтэр** / Ред. Г.Дагиймаа, Б.Бүлтэн; Техник ред. Б.Булган, Б.Одбаяр; Диз. Ч.Эрдэнэбат.- УБ.: Бэмби сан, 2020.- 160х.- ISBN: 9789919-20-534-8

Хүний бэлгийн хөгжил, эрхтэн системийн бүтэц зүй болон бэлгийн маргаантай асуудал, бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн таархи хууль эрх зүйн актууд, бэлгийн маргаантай асуудлыг шүүх эмнэлэгийн магадлан шинжилгээгээр тогтоох аргачлал зэрэг агуулгыг багтаасан байна.

67.5+28.706
Б 381

/НХУУТ-3, ХЗС-2/

ЭШФ Т-24013-24015

ШИНЖЛЭХ УХААН СУДЛАЛ



Монгол судлал: МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг: Боть XXXIII (359) / Эрхл. Ж.Баянсан, Б.Даваасүрэн.- УБ.: Битпресс, 2011.- 148х.

"Монгол судлал" эрдэм шинжилгээний цувралын энэ удаагийн дугаарт монгол хэлний харьцуулсан судалгааны зарим зүйл, эх бичиг судлал, хэлний сэтгэлгээний асуудал, утга зохиол, соёл судлал болон орчин үеийн уран зохиол, бүтээлийн шүүмж тэмдэглэл зэрэг сэдвийн хүрээнд холбогдох судалгааны илтгэл өгүүлүүд оржээ.

72+80
М 692

/ХНУУТ-2, ЛавФ-1/

ЭШФ Т-23995-23996



Монголын хүн амын сэтгүүл: № (550) 31 / Ред. А.Солонго, Ц.Болормаа, Б.Энхцэцэг ба бус.; Эхийг бэлт. З.Мөнхцэцэг; Хэвлэлийн диз. М.Норжинсүрэн.- УБ.: МУИС хэвлэлийн газар, 2021.- 75х.- ISSN 2226-1389

Энэ дугаарт Монгол улсын хүн амын анхны гэрлэлт дэх хүйсийн ялгаатай байдлын шинжилгээг гэрлэлтийн цэвэр хүснэгт ашиглан тооцсон хүн ам зүйн шинжилгээний үр дүн, КОВИД-19 цар тахлаас шалтгаалсан хямралын нөлөөллийг бууруулахаар Монгол улсын засгийн газраас авч хэрэгжүүлсэн нийгмийн хамгааллын арга

хэмжээг симуляци (хийсвэр тооцоолол)-ийн арга зүйгээр үнэлж, иргэдийн ядуурал, орлогын хуваарилалтад цар тахлын нөлөө байгаа эсэх, коронавирусаас үүдэлтэй хямралыг бууруулахад засгийн газрын бодлого хэр зэрэг үр дүнтэй байгааг үнэлсэн үнэлгээний үр дүн мөн Монгол улс дахь гадаад шилжилт хөдөлгөөний агрегат тоо, түвшинг тооцож, динамик хандлагыг дүгнэсэн судалгааны үр дүнг давхар тусгажээ.

72+60.7

М 692

/НХУУТ-3, ЛавФ-1/

ЭШФ Т-24531-24533

МУБИС-ийн түүхийн тэнхимийн эрдэм шинжилгээний сэтгүүл:

Acta historica: Т. XXI: Fasciculus 1-15 / Зөвлөлийн дарга Ж.Гэрэлбадрах; Нарийн бичгийн дарга Н.Сүхбаатар; Гишүүд Р.Сабиров, Т.Мэй, Б.Оюунбилиг, Ким Жангү, А.Старжинска, С.Жолт, А.Масахиро; Эрхл. Ч.Болдбаатар; Эх бэлт. Т.Энхтунгалаг; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 200х.- ISBN: 978-99978-871-6-0



МУБИС-ийн Түүхийн тэнхимээс эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүлийн энэ дугаарт угсаатан судлал, дундад үеийн түүх, ойрхи үеийн түүхэнд холбогдох судалгааны өгүүлэл, илтгэлүүд оржээ.

72+63.4

А 19

/НХУУТ-2/

ЭШФ Т-24514-24515

МУИС-ийн профессорын эрдмийн өв цуврал: Бүтээл туурвилын эмхэтгэл / Эмхт. Р.Дарьхүү, Д.Оюунгэрэл; Хэвлэлд бэлт. Ж.Лхагвадэмчиг; Эх бэлт. Э.Жаргалмаа; Диз. Б.Эрдэнэбулган.- УБ., 2020.- ISBN: 978-9919-504-22-9.

72+87.22

М 692



Б. I: Илтгэл, өгүүлэл логик, түгээмэл түүх.- 560х.

Энэхүү бүтээлд академич Содномжамцын Норовсамбуугийн философийн чиглэлээр туурвисан эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, бүтээлүүдээс дээжлэн эмхэтгэжээ.

/НХУУТ-5/

ЭШФ Т-24377-24381

Б.2:Философско-социологические проблемы

некапиталистического пути развития: Логика и методология научного исследования.- 448х.



Работа представляет собой сборник научных статей, докладов и работ академика С.Норовсамбуу в области философии

/НХУУТ-5/

ЭШФ Б-11273-11277

МУИС-ийн профессорын эрдмийн өв цуврал: Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл: / Эрхлэн хэвл. Д.Заяабаатар, С.Баттулга; Эмхэтгэж, хэвлэлд бэлт. Х.Шинэчимэг; Эх бэлт. Э.Уранбилэг; Диз. Б.Эрдэнэбулган.- УБ., 2020.- ISBN: 978-9919-504-27-4

Энэхүү бүтээлд доктор профессор Жамсрангийн Баясахын эрдэм шинжилгээний бүтээлүүдээс дээжлэн эмхтгэн оруулжээ.

72+66.4
М 692



Б. I: Гадаад харилцаа хийгээд соёл иргэншил.- 358х.

/НХУУТ-5/ ЭШФ Т-24382-24386

Б. II: Их Монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг.- 318х.

/НХУУТ-5/ ЭШФ Т-24387-24391



МУИС-ийн профессорын эрдмийн өв цуврал: Бүтээл туурвилын эмхэтгэл / Эрхлэн хэвл. Ж.Төртогтох; Эмхэтгэж, хэвлэлд бэлт. Д.Түмэнжаргал; Эх бэлт. П.Даваадорж; Диз. Э.Доржханд.- УБ., 2020.- ISBN: 978-9919-504-33-5

Энэхүү бүтээлд Монгол улсын гавъяат багш профессор Дашийн Содномгомбын бүтээлээс эмхэтгэн оруулжээ.

72+66.0
М 692



Б. I: Философи, улс төрийн философийн мэдлэгт.- 264х.

/НХУУТ-5/ ЭШФ Т-24392-24396

Б. II: Улс төр судлалын мэдлэгт.- 232х.

/НХУУТ-5/ ЭШФ Т-24397-24401



МУИС-ийн профессорын эрдмийн өв цуврал: Бүтээлийн чуулган: / Эрхлэн хэвл. Д.Заяабаатар, Ж.Эрдэнэбулган; Эх бэлт. Б.Пүрэвдэлгэр; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- УБ., 2020.- 263х.- ISBN: 978-9919-504-25-0

Энэхүү бүтээлд академич Содовсүрэнгийн Нарангэрэлийн туурвисан эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, бүтээлүүдээс дээжлэн эмхтгэжээ

72+67.3
М 692

Б. I: Нарангэрэл С. **Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шастир:** Бурхан халдун-Монгол туургатны голомт.- 263х.

/НХУУТ-5/ ЭШФ Т-24402-24406

Б. II: Нарангэрэл С. **Монголчуудын ёс суртахуун:** Бадрал, уналт, эргэн сэргээлт Монголчуудын зан суртахууны гарваль.- 212х.

/НХУУТ-5/ ЭШФ Т-24407-24411

Б. III: Нарангэрэл С. **Хуулийн амин сүнс буюу Чингис хаан, Монголчууд.**- 211х.

Энэхүү бүтээлд академич Содовсүрэнгийн Нарангэрэлийн туурвисан эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, бүтээлүүдээс дээжлэн эмхтгэжээ

/НХУУТ-5/ ЭШФ Т-24412-24416

МУИС-ийн профессорын эрдмийн өв цуврал: Бүтээл туурвилын эмхэтгэл: **Улс төр судлалын онол, практикийн асуудлууд** / Эрхлэн хэвл. Ж.Төртогтох; Эмхэтгэж, хэвлэлд бэлт. Д.Түмэнжаргал; Эх бэлт. М.Жавхлан; Диз. Б.Эрдэнэбулган.- УБ., 2020.- 284х.- ISBN: 978-9919-504-23-6

Энэхүү бүтээлд Монгол улсын гавъяат багш профессор Ширчингийн Содномын бүтээлээс эмхэтгэн оруулжээ.

72+66.0

М 692

/НХУУТ-5/

ЭШФ Т-24417-24421

Судалгааны арга зүй: Гарын авлага / Ред. Н.Сонинтамир, Н.Батдэлгэр.- УБ.: Нью Индиго, 2021.- 127х.- ISBN: 978-9919-24-653-2

Энэхүү гарын авлагад судалгааны ажил бичих үйл явц, мэдээлэл цуглуулах, түүнийг боловсруулах арга аргачлал зэргийг багтаасны дээр төгсөлттэй холбоотой бусад асуудлуудыг нэгтгэн, оюутан таны суралцах хугацааны төлөвлөлтөө амжилттай хийхэд тань тус нэмэр болохуйц зохион байгуулалтын шинжтэй бусад мэдээллүүдийг орууллаа.

72+65я7


С 701

/НХУУТ- 10, ГНОФ-10, БС-5/

ЭШФ Т-24457-24461

Эрдэм шинжилгээний бичиг: Газарзүйн асуудлууд=Journal of geographic issues / Ред. Д.Амартүвшин; Техник ред. Д.Ганпүрэв; Редакцийн зөвлөлийн гишүүд В.Батцэнгэл, П.Мягмарцэрэн, Д.Даш, М.Баянтөр.- УБ.: МУИС пресс, 2019.- 122х.

Энэхүү тусгай дугаарыг Газрын харилцааны ажилтны өдөрт зориулан гаргасан бөгөөд тус сэтгүүлд Газрын харилцааны ажилтан, эрдэмтэн, судлаачдын 20 гаруй илтгэлүүд оржээ.



72+26.8

Э 739

/БУУТ-2, ЛавФ-1/

ЭШФ Т-24328-24329



Эрдэм шинжилгээний бичиг: Физик: №31 (536) / Зөвлөлийн дарга Ж.Даваасамбуу; Гишүүд Б.Бурмаа, Н.Цогбадрах, П.Энхбаяр ба бус.; Дугаарыг эмхт. Г.Эрдэнэ-Очир.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2020.- 167х.- ISSN: 2311-1097

Тус дугаарт 2020 оны 11 сард зохион байгуулагдсан Үндэсний эрдэм шинжилгээний хурал дээр эрдэмтэн багш судлаачдын 30 гаруй илтгэлүүдийг багтаажээ.

72+22.3

М 692

/БУУТ-2, ЛавФ-1/

ЭШФ Т-24510-24511



Эрдэм шинжилгээний бичиг: Физик: № 32(553) / Зөвлөлийн дарга Ц.Ганцог; Гишүүд Ц.Ганцог, Б.Жадамба, Н.Цогбадрах ба бус.; Дугаарыг эмхт. Г.Эрдэнэ-Очир.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2021.- 71х.- ISSN: 2311-1097.

Уг бүтээлд эрдэмтэн багш судлаачдын Органик нарны зайн идэвхт гадаргуун гэрлийн шингээлтийг сайжруулах судалгаа, Гелийн атомын фотоэлектроны голограф, Тогтмол гүйдлийн соронзон орны 3D компьютер загвар бүтээх нь зэрэг 10 гаруй сэдвийн хүрээнд тавьсан эрдэм шинжилгээний илтгэлүүдийг багтаажээ.

72+22.3

М 692

/БУУТ-2, ЛавФ-1/

ЭШФ Т-24512-24513

БОЛОВСРОЛ. СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ УХААН



Даваа Ж. **Төлөвшил хүмүүжил хөгжил** / Эмхт. Ж.Даваа; Эх бэлт. П.Номинцэцэг; Диз. Ц.Түмэнжаргал.- УБ.: Соёмбо принтинг, 2021.- 168х.- ISBN: 978-9919-20-914-8

Уг бүтээлд Монгол иргэн бие хүний төлөвшлийн нийгэм сэтгэл зүйн асуудал, цахим тоглоом ба хүүхдийн хөгжил, хүмүүжил, сэтгэл зүйн зөвлөгөө ба ертөнцийг үзэх үзэл, үхлийн талаарх айдас ба түүнийг зохицуулах асуудал, харилцааны соёл эзэмших нь ёс суртахууны хэм хэмжээнд хүн өөрийгөө захируулах чухал алхам зэрэг асуудлын талаар дурджээ.

74.03

Д 121

/НХУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Б-30332-30334

Батцэнгэл Г. **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын сэтгэл зүйн үндэс** / Хян. О.Мягмар; Эх бэлт. Ж.Өнөрмаа; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- 4 дэх хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 284х.- ISBN: 978-99962-2-645-8

Уг номноос та, эцэг эх боловсролын салбарт ажиллаж суралцаж байгаа хэн хүнд хэрэг болохуйц онол арга зүйн чухал чухал санаанууд болон сургалтын арга зүйтэй танилцаж оношилгоо ба заслын олон арга техник эзэмших боломжтой болох болно. Мөн энд тухайн хүүхдүүдийн онцлогт таарсан судалгааны үлгэрчилсэн загварыг давхар оруулж өгчээ.

74.3

Б 33

/НХУУТ-7/

ЭШФ Б-30229-30231



Тусгай хэрэгцээт боловсрол / Х. Кензо, Т.Такаши, И.Шинзо ба бус; Ред. Г.Батцэнгэл; Хян. Г.Батцэнгэл, Ч.Байгалмаа; Хэл найруулга Г.Цогзолмаа, С.Эрдэнэцэцэг, Ч.Байгалмаа; Орч. С.Батхишиг, Б.Золзаяа, Н.Оюунтунгалаг, Б.Түвшинжаргал.- 2 дахь хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 244х.- ISBN: 978-99978-4-202-2

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношлогоо, эмчилгээ, асаргаа, тэдэнд боловсрол олгоход тохиолдох бэрхшээл, түүнийг даван туулах арга замын талаар тусгай хэрэгцээт боловсролын сургалтанд зориулан Японы профессор багш нарын боловсруулсан лекцийн материалыг орчуулан хүргэж байна.

74.3

Т 694

/НХУУТ-7/

ЭШФ Т-24101-24103



БИЕИЙН ТАМИР. СПОРТ

Загдсүрэн Д. **Спортын анагаах ухааны судалгаа, анализ.**- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 192х.- ISBN: 978-9919-20-967-4

Энэхүү номонд Монголын тамирчдын ажиллах чадварын дундаж, түүнд нөлөөлөх морфофизиологийн үзүүлэлт, судалгааг бүрэн эхээр нь толилуулжээ. Мөн 2016 оны олимпийн наадмын дараа таван тивийн тамирчид дэлхийн спортын их наадамд хэрхэн яаж өрсөлдсөнийг харьцуулсан сонирхолтой судалгаа, анализыг багтаажээ.

75.0

З 142

ЭШФ Т-24451-24452



Загдсүрэн Д. **Олимпийн хөдөлгөөнд түрлэг нэмсэн он жилүүд** / Ерөн. ред. Д.Отгонбаяр; Ред. З.Галхүү, Д.Лувсандорж, Ц.Цэн-Аюуш, Б.Баяртуяа, З.Гомбодорж; Хэвлэлийн диз. Б.Энх-Өлзий.- УБ.: 2021.- 397х.- ISBN: 978-9919-24-153-7

Энэхүү бүтээлд МҮОХ-ны ерөнхийлөгч Д.Загдсүрэн гуайн амьдрал, ажил үйлс болон ОУОХ-ны бодлогыг Монголд нутагшуулан хэрэгжүүлэх, спорт, олимпизм, спортын анагаах ухаанаар дамжуулан эргээд МҮОХ-г дотооддоо төдийгүй олон улсын тавцанд нэр хүндийг өргөсөн баг хамт олны нөр их хөдөлмөр гавъяа шагналын талаар дурджээ.



75.3+75.4
3 142

ЭШФ Т-24453-24454

ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ. СЭТГҮҮЛ ЗҮЙ



Монголын шилдэг нийтлэл: 99 боть / Ерөн. ред. Т.Баасансүрэн; Зөвл. Л.Түдэв, Ц.Дашдондов, Б.Лигдэн; Нарийн бичгийн дарга До.Чулуунбаатар; Зөвлөлийн гишүүд Д.Сарангэрэл, М.Зулькафиль, Б.Пүрэвдаш, Я.Сумъяа, Х.Цэвлээ, Д.Цэдэн-Иш, Л.Норовсүрэн, С.Лочин, У.Хүрэлбаатар; Эх бэлт. М.Наранчимэг; Диз. П.Содбаатар; Зөвлөн зохицуулагч М.Энхбаатар, Л.Ганзаяа.- УБ.: Мөнхийн үсэг, 2021.- 272х.- ISBN: 978-99973-2-329-3

76.01(1)
М 692

Цувр.83: Сандагсүрэн Д. **Л.Түдэвийн нийтлэлийн онцлог, ур чадвар:** Эрдэм шинжилгээний бүтээл.- 272х.

Судлаач Д.Сандагсүрэн энэхүү бүтээлдээ Л.Түдэвийн уран бүтээлийн баялаг сангаас зөвхөн сэтгүүлчийн үйл ажиллагааг товч тодорхойлохын зэрэгцээ аян замын тэмдэглэл, эсээ, асуудал дэвшүүлсэн өгүүлэл гэсэн төрөл зүйлээр хязгаарлан судалж, эдгээр төрөлд зохиолчийн ур чадвар, хэл найруулга, бичилтийн онцлогыг судлан шинжилсэн байна.

ЭШФ Б 30321-30322

Цувр.85: Эрдэнэбаяр Э. **Амьдрал миний дуранд.**- 303х.

Энэхүү ботид доктор профессор Эрдэнэсүрэнгийн Эрдэнэбаярын нийтлэл, гэрэл зургийн цоморлигийг тусгажээ.

ЭШФ Б 30323-30324

Цувр.87: Д.Шагдарсүрэн.- 352х.

Энэхүү цувралд доктор профессор Дамбын Шагдарсүрэнгийн нийтлэлүүдийг эмхтгэн оруулжээ.

ЭШФ Б 30325-30326

Цувр.89: Уянга Х. **Хэнхэлзүүр.**- 752х.

Тус цувралд Хайдавын Уянгын нийтлэлүүдийг эмхтгэн оруулжээ.

ЭШФ Б-30327-30328

Зурагт радио Монголд буюу Монгол телевиз 1967 он: Түүхэн баримт, мэдээлэл / Эмхт. С.Туяа, Г.Галбадрах, Д.Отгонбаяр; Диз. Д.Энхнаран; Хавтасны гэрэл зургийг Д.Цэрэннадмид.- УБ.: Мөнхийн үсэг, 2017.- 121х.

Монгол улсад телевизийн салбар үүссэний 50 жил, Монголын үндэсний телевиз анхны эфирээ цацсаны 50 жилийн үүх түүхийн баримт мэдээллийг эмхэтгэн оруулжээ.

76.03(1)

З 834

ЭШФ Б-30362-30363



МУЗЕЙН АЖИЛ, АРХИВЫН АЖИЛ

Музей судлал: Том. XXI-I Fasc. 1-22 / Ерөн. эрхлэгч Д.Сүхбаатар; Нарийн бичгийн дарга Д.Мөнхтоогоо; Гишүүд Д.Бумаа, Ч.Амартүвшин, Б.Баяртөр ба бус.; Эх бэлт. Ш.Эрдэнэцэцэг.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 227х.

"Музей судлал" нэрийг дахин сэргээж, музей судлалын онолын үзэл баримтлал, музейн түүх, цуглуулгыг судалгааны эргэлтэнд оруулж, монгол оронд музей судлалыг хөгжүүлэх зорилгоор бие даасан эрдэм шинжилгээний сэтгүүл бэлтгэн хүргэж байна. Сэтгүүлийн энэ дугаарт музей судлалын онол музейн түүх, соёлын өв цуглуулгын судалгаа, хадгалалт хамгаалалт зэрэг өргөн хүрээнд хийж буй судалгааны үр дүнгийн талаар тусгажээ.

79.1я5

М 865

ЭШФ Т 24323-24325



ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Уртнаст Н. Япон дахь Монголын нууц товчооны судлал.- Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2013.- 341х.- ISBN: 978-7-204-12731-3

Энэхүү бүтээлд Монголын нууц товчоо хэзээ яаж Япон арал дээр очсон талаарх судалгаа болон Японы эрдэмтдийн хийсэн орчуулга, шүүмж, тэмдэглэл мөн тус бүтээлтэй холбогдсон бусад хэлбэрийн судалгаануудын талаар дурджээ.

80(1)

У 511



ЭШФ Б-30157

Англи хэл: Суурь мэдлэгийн лавлах / Ерөн. ред. Б.Халиунаа; Ред. Ж.Хишигжаргал; Эрхл. Елизабет Шмиц-Венш; Орч. Б.Отгондулам; Орчуулгын ред. Г.Ариунцэцэг; Эх бэлт. Э.Энэрэл.- УБ.: Монсудар, 2020.- 336х.- ISBN: 978-99973-1-576-2

Уг бүтээл нь англи хэлийг хэрхэн сонсож, уншиж ойлгох, үг цээжлэх зэрэг сурах арга барил, хэрэглээний болон уран зохиолын төрөл бүрийн эхийг яаж ойлгох, боловсруулах, дүгнэх өөрөө зохион бичих талаар бодит хэрэглээнд тань тус болох зөвлөмж өгдгөөрөө онцлогтой. Түүнчлэн Америкийн англи хэл, Английн англи хэл зэрэг




англи хэлний үндсэн хувилбарууд, хэлзүй, зөв бичих дүрмийн чухал мэдлэгийг ч орхилгүй, эмх цэгцтэй тоймлон, жишээ, зураг зэргээр ойлгомжтой тайлбарлажээ.

81.2Анг

А 618

/НХУУТ-4, ГНОФ-4/

ЭШФ Б 30347-30349



Зайжөн Ү. **Монгол хэлний багц сурах бичиг** / Ред. М.Азжаргал; Эх бэлт. Б.Үүрийнтуяа.- УБ.: Соёмбо принтинг, 2021.- 146х.- (Жилиний Гадаад Хэлний Их Сургууль. Дорно Дахины Хэлний сургууль).- ISBN: 978-9919-24-050-9

Монгол хэл сурч буй хятад оюутны кирилл ба монголоор унших, бичих чадварыг хөгжүүлэхэд зориулсан энэхүү сурах бичигт монгол бичгийн зурлага, үсэг, үе, үг, дүрмийн тайлбар, уншлага, дасгалтай нийт 16 хичээл оруулжээ. Мөн монгол бичгийн зурлага, гийгүүлэгчээр төгссөн үйл үгс, холбох эгшиг авахуулагч нөхцлүүд, уламжлалт бичлэгтэй үгс, дүрс ялган бичдэг үгс, үг үүсгэх дагаврууд, монгол бичгийн уран бичлэг зэрэг 7 хавсралттай бөгөөд хятад хэлээр тайлбар зүүлт хийсэн байна.

81.2М-96

3-16

/НХУУТ-3/

ЭШФ Т 24311-24312



Их Монголын дөрвөлжин үсэг: Дөрвөлжин үсгийн 750 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл / Ариутган шүүсэн Р.Отгонбаатар.- УБ.: Сэлэнгэ пресс, 2021.- 136х.

Тус эрдэм шинжилгээний бүтээлд Монгол, БНХАУ-ын ӨМӨЗО, Австрали, Япон зэрэг улс орны Дөрвөлжин үсэг судлалын олон улсын эрдэмтэн мэргэдийн Дөрвөлжин үсгийн талаар шинэ тулгар баримт дэлгэн хэлэлцсэн олон илтгэлүүд оржээ.

81.2М

И 95

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Т 24344-24348



Солонгод Л.Хурцбаатарын хадгаламж судлал.- Elias Verlag Cologne,

Тус цуврал бүтээлд Монголчуудын бичиг соёлын үүсэл болон хөх Түрэг бичигийн дурсгал түүний үүслийн талаар судлах үүднээс эртний түрэгийн бичигт хөшөөдийн эх сурвалжуудыг судлан шинжилж чулууны түрэг бичээсийн хэлний үгийн бүтэц, үгийн утга болон эртний түрэг бичгийг уйгаржин монголоор унших арга зүй тайлбарыг тусгажээ.

Цувр. 2: **Монголчуудын уугуул бичгийн соёлын үүсэл буюу хөх Түрэг бичиг= The origin of the written culture of the Mongols or the old Turkic inscriptions** / Кириллээс буулгасан Л.Батмөнх; Зураг чимэглэл Р.Содбүрэн, М.Уудам; Найруулах комиссын гишүүн Л.Хурцбаатар, Д.Баатар.- 2018.- 440х.- ISBN: 978-3-943553-10-9

81.2М-8

С 554

/НХУУТ-2/

ЭШФ Т-24435-24436

Цувр.3: **Эртний түрэг бичээсний хэлний үгийн бүтцийн толь** / Эмхт. Б.Напил, Л.Хурцбаатар; Эх бэлт. Л.Хурцбаатар, В.Сарангоо, Ж.Жазгул, Солонгод Оюунбилэг; Диз. Л.Хурцбаатар.- 2020.- 219х.- ISBN: 978-3-943553-06-2

81.2М-4

С 554

/НХУУТ-2/

ЭШФ Т-24294, 24430-24432



Цувр.4: **1400 жилийн өмнөх өвөг Монгол хэл: Хүйс толгойн бичээс (НТ1)-ний судлал** / Эх бэлт. Л.Хурцбаатар; Кирил үсэгт буулгасан Э.Итгэл, Б.Амартүвшин; Диз. Л.Хурцбаатар.- 2020.-388х.- ISBN: 978-394355305-5

81.2М-03

С 554

/НХУУТ-2/

ЭШФ Т-24293, 24427-24429



Цувр 5: **Эртний түрэг бичээсний хэлний үгийн бүтцийн толь** / Хөрв. В.Сарангоо.- 440.- ISBN: 978-3-943553-12-3

81.2М-4

С 554

/НХУУТ-2/

ЭШФ Т-24291, 24433, 24434

АМАН ЗОХИОЛ



Ардын дүрслэлийн хэл / Ред. Н.Дариймаа; Хян. Ц.Оюундалай; Диз. Ч.Эрдэнэбаатар; Ариутган шүүсэн Н.Дариймаа.- УБ.: Бэмби сан, 2020.- 128х.- ISBN: 978-9919-20-719-9

Уг бүтээл нь урьд өмнө хэвлэгдээгүй, нийтийн хүртээл болоогүй эгэл ардын хэлцдэг сайхан үгс, аман билгийг 2012 оноос төрөл бүрийн хэлбэрээр цуглуулан, их дээд сургуулиудын эрдэм шинжилгээний бичиг эмхтгэлд хэвлүүлсэн илтгэл өгүүллийг эмхтгэн оруулжээ.

82.3(1)

Б 335

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б-30380-30382

УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ

Хариу шүүмж: Маргааны өгүүлэл / Эмхэтгэж хэвлэлд бэлт. Г.Нарантунгалаг; Хян. До.Цэнджав.- УБ.: Удам соёл, 2021.- 363х.- ISBN: 978-9919-20-88-2




Энэ номноос өнгөрсөн цаг үеийн сэтгэлгээний эмгэнэл, шинэ хуучны зөрчил, нэг намын үзэл баримтлалын хатуу чанд үзэл суртал, уран бүтээлч зохиолчийн эрх чөлөө хаалттай, бодсон санаснаа илэрхийлж чадахгүй халтираад улс төрийн тэрс үзэлтэн гэдэг хаяг зүүхэд тун ойрхон байсан талаарх одоогоос ная гаруй жилийн өмнөх үеийн мэдээ баримтыг олж унших болно.

83.3(1)

X 253

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б-30353-30355



Хасбаатар Л. **Р.Чойном, Л.Чулуунбаатар**: Солонгод Л.Хасбаатарын судалгааны шинэ бүтээл / Эмхт. Л.Хасбаатар; Хян. Б.Хасбилиг; Зураг чимэглэл Р.Содбүрэн.- Cologne Elias Verlag, 2015.- 479х.- ISBN: 978-3-943553-01

Энэхүү бүтээлд яруу найрагч Р.Чойном, Л.Чулуунбаатарын амьдрал уран бүтээлийг түүхэн баримт судалгаанд үндэслэн маш дэлгэрэнгүй тусган харуулжээ.

83.3(1)

X 263

ЭШФ Б-30314, 30356-30358



Цэндийн Дамдинсүрэн ба Монголын нууц товчоо: Монголын нууц товчооны 780 жилийн ойд зориулав / Эрхл. Б.Түвшинтөгс, Х.Цогтнарар; Ред. Х.Цогтнарар, Ч.Соргог; Уран сайхны ред. М.Тэгшжаргал.- УБ., 2020.- 150х.- ISBN: 978-99978-702-6-1

Тус бүтээлийг уншсанаар Ц.Дамдинсүрэн гуайн товч намтар, Монголын нууц товчоог эхлэн орчуулах болсон нөхцөл бололцоо хүчир бэрхшээл зэрэгтэй танилцахын дээр түүний орчуулгын "Монголын нууц товчоо" нь монгол судлал болон дунд бага сургуулийн сурах бичигт хэр нөлөөтэй байсныг мэдэх боломжтой.

83.3(1)

Ц 959

/НХУУТ-5/

ЭШФ Т-24502-24506



Чин улсын сүүлчийн үеийн Монгол бага сургуулийн сурах бичиг: Манж, Монгол, Хятад гурван хэл хавсарсан сонгодог утга зохиолын цуврал / Эмхт. Эрхэмт.- Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2015.- 384х.- ISBN: 978-7-204-13550-9

Энэхүү бүтээлд Хааны бичиж орчуулсан дөрвөн бичиг, Их суртахуй бичиг, Ер дунд бичиг, дөрвөн бичиг-шүүмжлэл өгүүлэл бичиг, хааны бичсэн Монгол, Хятад хавсарсан шүлэглэлт ном, Хааны бичсэн Монгол, Хятад хавсарсан ёслолт ном, Хааны бичсэн Монгол, Хятад хавсарсан шашинт ном, Манж, Монгол, Хятад хавсарсан Богдын сургаалыг сийрүүлэн бадруулсан бичиг зэргийг хураангуйлан оруулжээ.

83.3(545)я71


Ч 63

ЭШФ Б-30158

УРАН ЗОХИОЛ

Батжаргал Д. **Икс хөлт:** Ахлах, дунд насныханд зориулсан өгүүллэгүүд / Ред. Ч.Наранцэцэг; Хавтасны зураг Ц.Цагаанбилиг; Диз. Ч.Эрдэнэбат.- УБ.: Бэмби сан, 2020.-95х.- ISBN: 978-9919-20-720-5

Хүүхдийн ёс суртахуун хүнлэг чанар, хүн байхын ухааныг хөндсөн "Икс хөлт", "Бяцхан мисс", "Англи хэлний шинэ багш", "Сэтгэл нь бүтэн", "Бичигт шуудан" зэрэг зохиолчийн урьд өмнө хэвлэгдээгүй сонирхолтой өгүүллэгүүдийг эндээс уншаарай.



84(1)-44

Б 335

/ХНУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б-30383-30385

Монголын утга зохиол туурвил зүйн шилдэг бүтээлийн цоморлог: 5 боть / Ред. Б.Цэнддоо; Техник ред. Б.Нэргүй; Хавтасны диз; Н.Бямбацогт Эх бэлт; Д.Цэрэндулам.- Анхны хэвл.- УБ.: Нэпко, 2020.- 308х.- ISBN: 978-9919-500-47-4

XX-XXI зууны зааг үеийн Монголын утга зохиолын томоохон төлөөлөгч Цэндийн Доржготовын уран бүтээлийн цоморлогийг уншигч танд барьж байна.

84(1)-44

Д 542



Б.1: Доржготов Ц. **Улаан орхимжны давлагаа.**- 248х.


Уг бүтээлд хүний төрөлх мөн чанар, ёс суртахууны сэдвийг хөндсөний дээр их хэлмэгдүүлэлтийн үед эзгүй хээр, ганга сайранд нууцаар хэдэн зуугаараа буудуулсан лам хуврагуудын тухай өгүүлжээ.

84(1)-44

Д 542

/ХНУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Т-24119-24121



Б.2: Доржготов Ц. **Шим мандал:** Роман.- 308х.

Уг романд илгээлтийн эздийн эх оронч дэврүүн үзэл, хөдөө хөрж, гадаа гандаж, ядарч зүдрэхийг огоорон эх орны хатуу ширүүн хар ажлыг нугалж явсан хийгээд тэдний нүцгэн талд бий болгосон бүхэн өдгөө газар тариалан сэргэхэд суурь болсон талаар өгүүлжээ.

/ХНУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Т-24125-24127

Б.3: Доржготов Ц. **Усны үнэр.**- 421х.

Зохиолчийн энэхүү бүтээлд үе үеийн нас насны хүмүүсийн амьдрал, ажил үйлс, амжилт бүтээл болон тэдний амьдралын зовлон жаргал, хайр дурлал, гомдол харуусал зэрэг хүмүүний амьдралын олон өнгийг харуулсан сонирхолтой олон өгүүллэгүүд нь багтжээ.

/ХНУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Т-24128-24130





Б.4: Доржготов Ц. **Тэнгэр дуугарахын өмнө**.- 332х.

Тус ботид: 90 хоногийн оргодол, Төөрсөн авъяас, Цагийн өнгө, Үзэсгэлэн гоо, Тэнгэр дуугарахын өмнө, Нөгөө нэг явдал, Эзгүй хээрийн өнчин суварга, Бурхны ходоод лонх биш зэрэг туужууд нь орсон байна.

/ХНУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Т-24131-24133



Б.5: Доржготов Ц. **Будааны хүүхэд**.- 324х.

Энэ ботид зохиогчийн инээд баясал хайрлаж ухаарал дагуулсан, уран хэтрүүлэг, хошин шигтгээг донжийг нь тааруулж гялтгануулсан 80 гаруй хошин өгүүлэлийг нь эмхтгэсэн ажээ.

/ХНУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Т-24134-24136



Б.6: Доржготов. **Бид хэн бэ?**.- 378х.

Ингэхэд бид хэн бэ? Гишгэсэн мөрөө эргэж хар!, Сүүдрээ ажиглаж биеэ зас! гэдэг монгол сургаал дор 1990 оноос хойш Монголын нийгэмд гарсан өөрчлөлт, авлигал, ардчилалын 30 жилд улс төрд шургалсан олигархиуд хулгай луйвраа төрийн нууц дор хамгаалдаг улс төрийнхний бохир технологи, монголын эдийн засаг нийгмийн хөгжлийг гацаасан орсон цаад учир шалтгаан зэргийг баримтад тулгуурлан өгүүлсэн шаналал егөөдөл, харуусал тэмүүлэл шингээсэн эрэгцүүлэл нийтлэлүүд нь тус ботиос уншаарай.

/ХНУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Т-24137-24139



Лхаасүрэн Л. **Жүжгийн түүвэр** / Хавтасны диз. Л.Энхбаатар, В.Баатархүү; Диз. Ш.Цогт.- УБ.: Жиком пресс, 2016.- 301х.- ISBN: 978-99973-72-92-5

Зохиолч, орчуулагч, найруулагч, жүжигчин, багш Л.Лхаасүрэнгийн уран бүтээлийн энэхүү эмхтгэлд түүний орчуулсан “Аргагүй эрхэнд оточ”, “Бэрд” инээдмийн жүжиг, “Аймшигт анчин Пандуухайн паян”, “Гахайн ганц тоорой”, “Зүггүй Шөмбөөлэй” хүүхдийн жүжиг, “Ханиа сонгосон нь” хошин жүжиг, “Цэцэг битгий тасал” мультфильм зэрэг зохиолууд нь багтсан байна.

84(1)-6
Л 873

ЭШФ Б-30370-30372

Линдгрэн А. **Жаалхүү Карлсон хоёрын тухай гурван тууж** / Ред. Ц.Сүхбаатар; Техник ред. Ж.Оюунаа; Эх бэлт. Ц.Билгүүн; Зураач Илүн Викланд; Орч. Н.Пүрэвдагва; Диз. Ц.Оюунтүлхүүр.- 3 дахь хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 376х.- ISBN: 978-99962-1-660-2

Дээвэр дээр суудаг Карлсон дэлхий дээгүүр аялсаар явна. Түүнийг танихгүй хүүхэд манай гаригт лав үгүй биз ээ. Нуруундаа сэнстэй тэрхүү хөгжөөнт баатар үе үеийн хүүхэд багачуудын дотно найз болж үнэхээр чаджээ. Эрт цагийн үлгэрийн өнгө аясаар эдүгээ үеийн хүүхдийн бодол сэтгэлийг нээн харуулсан Астрид Линдгрений энэхүү гурвал тууж дэлхийн хүүхдийн утга зохиолд шинэ үзэгдэл болсон юм. Тийм дээ ч бага Нобелийн шагнал гэгддэг хүүхдийн уран зохиолын дээд шагнал Х.Х.Андерсений алтан медаль хүртсэн юм.



84(4Шв)-44

Л 58

ЭШФ Б-24455-24456

УРЛАГ. УРЛАГ СУДЛАЛ

Балдан Ё. **Тайзны орон зайн хөдөлгөөн** / Ред. Н.Пүрэвдагва; Эх бэлт. Б.Баярбаатар; Хавтасны диз. Б.Баярбаатар; Гэрэл зургийг Д.Цэрэннадмид.- УБ.: Жиком пресс, 2017.- 284х.- ISBN: 978-99978-60-04-0



Энэхүү бүтээлд жүжиг тоглож, дүр бүтээдэг газар маань машин техниктэй холилдож, илтгэл айлдвар уншдаг төдий газар болон хувирч байгаад шүүмжлэнгүй хандаж, хүмүүсийг аандаа урсах амьд хөдөлгөөний хэлбэрлүү буцаах мөн театр өөрөө амьд байхын тулд үзэгчидтэйгээ хэрхэн харьцах нөхцлийг бүрдүүлэхээс ажлаа эхлэх хэрэгтэй төдийгүй тайзны орон зайг зөв ашиглах жүжигчний ур дүйн талаар өгүүлжээ.

85.334

Б 223

ЭШФ Б-30375-30376

Балдан Ё. **Тайзны хөдөлгөөнөөр дүрслэх арга ба жүжигчний дасгал** / Ред. Д.Отгонбаяр; Эх бэлт. Л.Номин; Хавтасны диз. Г.Жавхлан; Хавтасны гэрэл зургийг Г.Цэрэннадмид.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 196х.- ISBN: 978-9919-21-690-0



Энэхүү бүтээлд театрын урлаг бол орон зай дахь хөдөлгөөн үйлдлийн урлаг төдийгүй театрын хэв маяг дүрслэн илэрхийлэх арга, амьдралын олон хэв төрхийг үйл явдлын өрнөл дунд нь үзүүлэхийг зорилгоо болгодог талаар тусгасны сацуу жүжигчний илэрхийлэх хэрэгсэл болсон хөдөлгөөний боломжийн тухай дурджээ.

85.334

Б 223

ЭШФ Б-30377-30379

Барбаатар Г. **Бүжиг бол ухааны урлаг** / Ред. Ж.Долгорсүрэн; Эх бэлт. С.Нарантуяа; Форзны зураг З.Уянга.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 160х.- ISBN: 978-9919-20-427-3



Энэхүү бүтээлд Монголын балетын урлагийг үндэслэн байгуулагчдын нэг, балетмейстер Б.Жамъяндагва багшийн амьдрал, уран бүтээл, түүний хэвлэлд өгсөн ярилцлага, уран бүтээлийн


жагсаалт, мөн хамтран зүтгэгч, шавь нарынх нь сэтгэлийн өргөл талархлыг хамтатган ЭМХЭТГЭЖЭЭ.

85.327

Б 27

/НХУУТ-5/

ЭШФ Т-24422-24426




Гротовски Ё. **Ядмаг театраас хөтлөгч урлаг руу: 1933-1999** / Орчуулгын ред. С.Туяа; Орч. Н.Пүрэвдагва.- УБ.: 2016.- 208х.- ISBN: 978-99929-3-812-6

Тус бүтээлд жүжигчдийн бэлтгэл сургуулилт ямар байх, найруулагч гэж чухам хэн бэ? жүжигчин, найруулагч, үзэгчдийн хоорондын амьд холбоог хэрхэн буй болгох гээд олон ойлголтыг тайлбарласан байна. Бас жинхэнэ багш, жинхэнэ шавийн тухай ч тодорхойлжээ. Энэ ном өнөөдрийн хийгээд ирэх цагийн өнгийг илтгэх тайз дэлгэцийн урлагийн уран бүтээлчид, жүжигчид, мэргэжлийн сургуулийн оюутнуудад гарын авлага болох болно.

85.334

Г 653

ЭШФ Б-30373-30374



Мейерхольд В.Э. **Өгүүлэл, захидал, хэлсэн үг, яриа: 1874-1940** / Орчуулгын ред. С.Туяа; Орч. Н.Пүрэвдагва.- УБ.: Жиком пресс, 2013.- 560х.- ISBN: 978-99973-44-304

Энэхүү бүтээлд тайз, дэлгэцийн урлагийн онолч, сэтгэгч, найруулагч В.Э.Мейерхольдын бичсэн өгүүлэл, захидал, хэлсэн үг зэргийг эмхэтгэсэн энэхүү бүтээлд тайз, дэлгэцийн урлагийнхан тухайн цаг үе-нийгмийн сэтгэлзүйг хэрхэн анхаарах, тайз дэлгэцийн урлагийн цаашдын чиг хандлага ямар байх, тайзны урлагийн бодит илэрхийлэл, нөхцөлт илэрхийлэл, биомеханикийн аргачлал, тайзны урлагийн түүх, найруулга зүй, жүжиглэх урлагийн талаар өргөн мэдээллийг багтаажээ.

85.33

М 35

ЭШФ Б-30359-30361



Отгонбаяр Д. **Найруулагч багш Л.Лхаасүрэн: 1946-2010** / Ред. Н.Пүрэвдагва.- УБ.: Жиком пресс, 2016.- 251х.- ISBN: 978-99978-4-186-5

Лайхансүрэнгийн Лхаасүрэн эгэл аавын хүү, ах, хүний хань, аав. Харин Монголын театр урлагийн ертөнцөд драм дэлгэцийн аль алинд өөрийгөө харуулж чадсан жүжигчин. Нөгөө талаасаа найруулагч, жүжгийн зохиол орчуулдаг, бичдэг хүн байв. Энэхүү намтар бүтээлд түүний бага наснаас эхлэн жүжигчин, найруулагч, багш Лхаасүрэнгийн амьдрал уран бүтээлийн тухай өгүүлжээ.

85.33(1)г

О-533

ЭШФ Б-30367-30369

Эрдэнэхорлоо Ж. **Монгол бүжиг судлал**: Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл / Ред. Г.Жамъяндорж; Эх бэлт. Ч.Болормаа.- УБ.: Линограф, 2020.- 243х- ISBN: 978-9919-20-395-5



Монгол бүжгийн онол, түүхийн талаархи судалгааны илтгэл, өгүүлүүд багтжээ. Тухайлбал: Монголын бүжгийн урлагийн нэрт зүтгэлтэн Ц.Сэвжид, Б.Жамъяндагва, Д.Нанжид, Г.Долгорсүрэн С.Сүхбаатар нарын уран бүтээлийн тухай судалгааны илтгэлүүд, их тайзнаа тавьсан Ц.Нацагдоржийн "Нүүдэл" бүжгэн жүжиг, Х.Алтангэрэлийн "Төгсгөлгүй" балетын хөгжмийн шүүмж орсон байна.

85.32(1)


Э 739

/НХУУТ-7/

ЭШФ Т-24494-24496

ГҮН УХААН

Гантөмөр Д. **Аялахуй: "Би"-гийн эрэлд**: Буддын гүн ухаан; соёл; аялал жуулчлалын талаархи судалгааны өгүүлэл, илтгэлийн эмхтгэл / Ред. М.Гантуяа; Эх бэлт. Т.Данзан; Хавтасны зураг Ц.Солонго; Шүүмж өгсөн Г.Чулуунбаатар, С.Гантөмөр.- УБ.: Кристал пресс, 2020.- 116х.- ISBN: 978-9919-23-930-5



